



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-33

- 1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн нийцэл, үр нөлөө, газар олголтод хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг сонсох* 6-33

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 03 дугаар сарын 29-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Саранчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 17 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Томилолттой: Ж.Бат-Эрдэнэ, Г.Тэмүүлэн, Т.Энхтүвшин;
Чөлөөтэй: Х.Болорчулуун, Н.Наранбаатар, Ц.Туваан.*

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлж, хэлэлцэх асуудлын дараалалд орсон Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хойшлуулахаар тогтов. /10.25/

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен үг хэлэв.

Нэг. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн нийцэл, үр нөлөө, газар олголтод хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх, Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын дарга Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Д.Баттулга, Ахлах аудитор И.Эрдэнэцэцэг, аудитор Х.Энх-Амгалан, Ахлах шинжээч Ж.Дэмчигсүрэн, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, мөн яамны Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газрын дарга Г.Эрдэмбилэг, Ерөнхий нягтлан Л.Оюунчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн нийцэл, үр нөлөө, газар олголтод хийсэн Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Ж.Батжаргал, Г.Мөнхцэцэг, Г.Дамдинням, Ш.Адъяаа, Н.Ганибал, Г.Ганболд, Б.Саранчимэг нарын тавьсан асуултад Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх, Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын дарга Д.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн нийцэл, үр нөлөө, газар олголтод хийсэн Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын тайланг сонсов.

Уг асуудлыг 11 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 01 цаг 35 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 11 цаг 52 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.САРАНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан”
танхим
10 цаг 17 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Саранчимэг: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар мэндийг айлтгая.

Тэгээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж 52.6 хувьтай болсон учраас Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 03 сарын 29-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог, нэрээр нь танилцуулъя.

Цогт-Очирын Анандбазар Булган аймаг, 4 дүгээр тойрог. Ирээгүй байна. Тилеуханы Аубакир Баян-Өлгий аймаг. Ирсэн байна. Жадамбын Бат-Эрдэнэ Булган аймаг. Орон нутагт ажилтай байна. Жигжидийн Батжаргал Төв аймаг. Ирсэн байна. Буланы Бейсен Баян-Өлгий аймаг. Ирсэн байна. Хаянгаагийн Болорчулуун Дорнод аймаг. Ирээгүй байна. Гочоогийн Ганболд Өвөрхангай аймаг. Ирсэн байна. Наянтайн Ганибал Сүхбаатар. Ирээгүй байна. Гонгорын Дамдинням Дархан-Уул аймаг. Ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат Хэнтий аймаг. Ирсэн байна. Гомпилдоогийн Мөнхцэцэг Дундговь, Говьсүмбэр. Ирсэн байна. Нанзадын Наранбаатар Өмнөговь.

Чөлөөтэй. Дамдинсүрэнгийн Өнөрболор Сэлэнгэ. Ирээгүй байна. Батсүхийн Саранчимэг Баянзүрх. Ирсэн байна. Ганзоригийн Тэмүүлэн Архангай. Орон нутагт томилолттой байна. Цэвэгдоржийн Туваан Төв аймаг. Ирээгүй байна. Одонгийн Цогтгэрэл Увс аймаг. Ирсэн байна. Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн Завхан аймаг. Ирсэн байна. Төмөртоогогийн Энхтүвшин Дорноговь. Гадаадад томилолттой байна. Наянтайн Ганибал Сүхбаатар аймаг. Ирсэн байна.

Ирц 57.9 хувь болсон байна. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя.

Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулиудын төслийн анхны хэлэлцүүлэг байгаа.

Хоёр. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн нийцэл, үр нөлөө, газар олголтод хийсэн Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын тайланг сонсох байгаа.

Та бүхэн хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Энэ Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсгийн дарга ирээгүй байна. Ажлын хэсэгт орсон гишүүд байвал бас тэр дээр саналаа хэлээдхээч. Ж.Батжаргал гишүүн орсон байгаа. Тийм ээ. Тийм. Өнөөдрийн хурлаар орчихсон байгаа. Өмнө нь өөрсдөө орчихсон байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр ажлын хэсгийн ахлагч энэ дээр. Ж.Батжаргал гишүүний микрофоныг өгье. Энэ Байгалийн ургамлын тухай хуулийн ажлын хэсэгт

орсон байгаа. Дарга нь ирээгүй байна.
Ц.Анандбазар гишүүн ирээгүй байна.

Ж.Батжаргал: Та бүгдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Би дараалал алдаад яваа юм байна. Өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хэлэлцэж байна гэж бодоод суугаад байсан юм.

Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөн дотор байж байгаа. Энэ сард манай Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын төлөвлөгөөн дээр санал надад байгаад байгаа юм. Тэр Байгалийн ургамлын тухай хуулийн төсөл хэлэлцүүлэгт бэлтгэх санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсэг дээр өчигдөр яригдсан. Уг хуулийн төсөл өмнөх бүр эрхийн хугацаанд өргөн баригдаж хэлэлцэх эсэх асуудал нь чуулганаар хэлэлцэгдсэн юм билээ.

Тэгээд дэд ажлын хэсэг ажлын хэсгийн доор байгуулагдчихсан. Тэр дэд ажлын хэсгийн танилцуулж байгаа санал, хуулийн төслийг аваад үзэхээр зэрэг байгалийн ургамлынхаа асуудлыг бүрэн зохицуулсан харилцаа нь тодорч гарч ирэхгүй. Үзэл баримтлалын хувьд тийм алдаатай заалтууд дотор нь нэлээдгүй байгаад байгаа юм.

Тийм учраас өчигдөр ажлын хэсэг дээр ярилцаад тухайлсан тухайлсан заалтуудыг илүү сайжруулж саналын томъёололд бэлтгэж оруулж ир гэдэг байдлаар хойшлуулчихсан.

Тэгэхээр ер нь энэ хуулийг Байнгын хороон дээр юм уу, ажлын хэсэг дээрээ дахиж нэлээн нарийн ярьж, нэлээн сайн чамбайруулахгүй бол хууль зүйн техник талаасаа ч тэр, үзэл баримтлал дотор нь орсон заалтуудын зохицуулалт

талаасаа ч тэр, найруулга талаасаа ч тэр нэлээн тийм доголдолтой хууль гарчих гээд байна уу даа гэмээр ийм зүйл харагдаж байгаа.

Тийм учраас би үүнийг энэ сарын хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнөөс хасах нь зүйтэй. Хойшлуулж л ярихаас арга байхгүй. Тэгээд мэдээж хэлэлцэх эсэхийг нь дэмжчихсэн санал байгаад байгаа учраас бид ямарваа нэгэн байдлаар ажиллаж үүнийг сайжруулж оруулж ирэх ёстой. Төсөл өргөн баригч татаж аваагүй тохиолдолд бид үүнийг чинь явуулдаг. Технологи бүхий оронд явуулахаас өөр арга байхгүй шүү дээ.

Тийм учраас хойшлуулах нь зүйтэй байх гэсэн ийм саналтай байна.

Б.Саранчимэг: Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд дээр ажлын хэсэг хойшлуулах саналтай байгаа учраас эхний асуудлаа хойшлуулъя. /алх цохив/

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн нийцэл, үр нөлөө, газар олголтод хийсэн Аудитын газрын гүйцэтгэлийн аудитын тайланг сонсох байгаа.

Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүн байна уу? Б.Бейсен гишүүн.

Б.Бейсен: Энэ хаврын тариалалт эхлэх гэж байна. Хүнсний ногооны асуудал.

Ерөнхийлөгчийн санаачилсан хүнсний аюулгүй байдалтай холбоотой санаачилга, тогтоол байж байгаа. Ерөнхийлөгчийн. Гэтэл өнгөрсөн жил 2022 онд өчнөөн зуун тэрбум төгрөг

хаврын тариалалт, ургац хураалтад жижиг, дунд үйлдвэрт өгсөн. Энэ үр дүн байхгүй. Ерөөсөө.

Одоо энэ танил тал харсан, намын харьяаллаар хуваарилаад жижигхэн талбайтай улсуудад хуваарилаад өгчихдөг. Дотооддоо эх орны хөрсөнд ургасан хүнсний ногоогоор хангах боломж байгаа л даа. Гол дагасан сумууд. Хуучин сангийн аж ахуй байж байсан сумууд ч байж байна. Энэ дээр анхаараад 2023 онд тавьсан төсвийн хуваарилалтын асуудал дээр анхаараад явбал дотооддоо хүнсний, ядахдаа төмс, ногоо, байцаа, лууван, сонгино, помидор, огурцыгаар хангах боломж байгаа юм байна. Энэ тал дээр бас хэлэлцэж Хөдөө аж ахуйн яамныхныг оролцуулж энэ сарын

хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулаад шийдвэл ямар вэ гэдэг санал байна.

Б.Саранчимэг: Б.Бейсен гишүүний саналыг сонслоо.

Тэгэхээр Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Х.Болорчулуун сайд өнөөдөр хуралдаа ирээгүй байна. Тэгэхээр ер нь асуудал орохдоо дандаа бэлтгэж оруулдаг.

Тэгэхээр үүнийг дараагийн асуудал дээр ярилцаад явъя. Одоо өөр хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байхгүй учраас хэлэлцэх асуудлаа баталлаа. /алх цохив/

Нэг.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн нийцэл, үр нөлөө, газар олголтод хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг сонсох

Нэгдүгээр асуудал. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн нийцэл, үр нөлөө, газар олголтод хийсэн Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын тайланг сонсьё.

Тэгээд энэ тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоолын дагуу Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн нийцэл, үр нөлөө, газар олголтод Үндэсний аудитын газраас гүйцэтгэлийн аудит хийж, зөвлөмж гаргасан байгаа.

Тэгэхээр аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитын орлогч Я.Сарансүх танилцуулна.

Өнөөдрийн хэлэлцэх асуудалтай холбогдуулж ирсэн ажлын хэсгийг Та бүхэнд танилцуулъя.

Я.Сарансүх Монгол Улсын Ерөнхий аудитын орлогч, Д.Энхболд Гүйцэтгэл Нийцлийн аудитын газрын дарга, Д.Баттулга Гүйцэтгэл-Нийцлэлийн аудитын газрын аудитын менежер, И.Эрдэнэцэцэг Ахлах аудитор, Х.Энх-Амгалан аудитор, Ж.Дэмчигсүрэн Ахлах шинжээч.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, Г.Эрдэмбилэг Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газрын дарга, Л.Оюунчимэг Ерөнхий нягтлан. Ирсэн байна.

Танилцуулгыг сонсьё. 3 номерын микрофоныг өгье. Өөрсдийгөө танилцуулаад явчхаарай.

Я.Сарансүх: Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ,

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоолын дагуу Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн нийцэл, үр нөлөө, газар олголт сэдэвт аудитыг гүйцэтгэж дүгнэлт, зөвлөмжийг гаргалаа.

Аудитыг дараах зорилтын дагуу хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль нь холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн акттай нийцэж байгаа эсэх, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт нь үр нөлөөтэй эсэх, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн дагуу газар олголт хийсэн эсэх, өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжсэн эсэхэд аудитыг чиглүүлэн ажиллалаа.

Аудитад Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлага, түүний харьяа хамгаалалтын захиргаад, Богд хаан уулын дархан цаазат газар, Горхи, Тэрэлж, Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газар, Газар зохион байгуулалт, геодез, зураг зүйн газар, Татварын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар болон төрийн холбогдох эрх бүхий байгууллагуудын 2019-2022 оны 3 дугаар улирлын байдлаарх газар олголт, газар ашиглахтай холбоотой шийдвэр, үйл ажиллагааг түүвэрлэн хамруулсан болно.

Аудитын дүнгээс товч танилцуулбал Газар зохион байгуулалт, геодез зураг зүйн газрын мэдээллийн сангийн 2022 оны 10 дугаар сарын байдлаарх мэдээллээр улсын хэмжээнд дархан цаазат газар нутагт өмчлөх хэлбэрээр 127 байршилд 1.5 га, эзэмших хэлбэрээр 1407 байршилд 2364.5 га, ашиглах хэлбэрээр 1775 байршилд 5848.3 га газар олгосон байна.

Байгалийн цогцолборт газарт өмчлөх хэлбэрээр 1582 байршилд 361 га, эзэмших хэлбэрээр 3659 байршилд 16 мянга 109.9 га, ашиглах хэлбэрээр 1870 байршилд 131 мянга 285.3 га газар олгосон байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт 2021-2022 онд үйл ажиллагаа явуулсан 601 иргэн, хуулийн этгээдтэй газар ашиглах гэрээг байгуулаагүй, 436 иргэн, хуулийн этгээдийн гэрээний биелэлтийг дүгнээгүй байна.

Богд хан уулын дархан цаазат газарт 40 мянга 853.5 сая төгрөгийн, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт 1089.9 сая төгрөгийн, Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт 35.5 сая төгрөгийн газрын төлбөрийг төвлөрүүлээгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого жил бүр 10-аас 13 хувь нэмэгдэж байгаа боловч зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх нь тодорхойгүй. Тухайн төсвийн жилд орон нутгийн төсөвт төвлөрсөн орлогоос хуульд заасны дагуу хамгаалах болон нөхөн сэргээх зардалд заасан хувиар санхүүжүүлээгүй байна. Тухайлбал, 2021 онд байгалийн нөөц ашигласны төлбөрөөс 46.6 тэрбум төгрөг зарцуулахаас хуулийн хэрэгжилт 26.2 хувьтай байна.

Аудитын дүнд үндэслэн дараах гол дүгнэлтийг гаргасан. Үүнд:

Тусгай хамгаалалттай газар нутагт газрын ерөнхий төлөвлөгөөгүй, зохион байгуулалтгүйгээр газар олгосон нь газар нутгийг хамгаалах үндсэн зорилтыг хангаагүй. Монгол Улсын нэгдэн орсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Биологийн олон янз байдлын тухай конвенцын зорилтыг хангаж чадахгүй байна.

Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын хэмжээнд газрын кадастрын бодлогыг хэрэгжүүлэх улсын газрын мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газрын улсын бүртгэл, газрын тоо бүртгэл, чанар, үнэлгээ, төлбөр, шилжилт хөдөлгөөн, газар хамгаалах талаар авсан арга хэмжээ зэрэг үзүүлэлтийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүрээр тусгах ажлыг хэрэгжүүлэхдээ төрийн бусад байгууллагатай уялдаа холбоогүй ажилласнаас газрын мэдээллийн нэгдсэн санг бүрэн хөтлөөгүй, мэдээлэл зөрүүтэй байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль 1994 онд батлагдаж, 1997-2022 оны хооронд 15 удаа нэмэлт, өөрчлөлт орсон ч холбогдох харилцааг бүрэн зохицуулж чадахгүй байгаагаас нийгэм, эдийн засаг, хот төлөвлөлт, хүн амын өсөлт зэрэг өнөөгийн нөхцөл байдалд нийцүүлэн хуулийг шинэчлэн найруулах шаардлага үүссэн байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Улсын Их Хуралд 2 асуудал толилуулж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад 10 зөвлөмж өгсөн.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Саранчимэг: Я.Сарансүх даргад баярлалаа.

Өнөөдрийн хуралд Цогт-Өчирын Анандбазар Булган аймаг. Ирсэн байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж хүрэлцэн ирсэн ажлын хэсгийг танилцуулсан байгаа.

Тэгэхээр аудитын тайлантай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү.

Г.Ганболд гишүүнээр тасаллаа. Т.Аубакир гишүүн асуултаа асууя.

Т.Аубакир: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Тусгай хамгаалалттай газрын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсэг гэж байгуулагдсан. Ж.Батжаргал гишүүнээр ахлуулаад тусгай хамгаалалттай газрууд дээр бас гишүүд хуваарилагдаад аймгууд болон нийслэлд байгаа газрууд дээр яг биечлэн очиж ажилласан байгаа.

Ингэх явцад бас нэлээн цэгцлэх шаардлагатай, хуулийн зохицуулалтад өөрчлөлт оруулах зүйлүүд нэлээн их ажиглагдсан. Үүний хүрээнд манай аудит маань бас дүгнэлт гаргаад зөвлөмжүүдээ хүргүүлж байгаа юм байна. Нэлээн няхуур хийсэн болов уу гэж ойлгож байна. Яагаад гэвэл тусгай хамгаалалттай газар, байгалийн цогцолборт газрууд маргаан дагуулдаг. Ялангуяа нийслэлд байж байгаа тусгай хамгаалалттай газрууд. Тийм ээ.

Хоёр асуулт байгаа юм. Энэ тусгай хамгаалалттай газрын захиргаа

байгуулах тал дээр үүний өмнөх Байнгын хорооны хурал дээр би удаа дараа саналуудаа хэлж байсан байгаа л даа. Байгаль орчны сайд, манай аудитынхан байж байгаа юм байна.

Тусгай хамгаалалттай газрын захиргаа байгуулахад аль нэг аймаг дээрээ илүү газар эзэлж байгаа газартаа тэр тусгай хамгаалалттай газрын захиргааг нь байгуулах нь зөв юм гэж. Жишээлбэл, манай Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумд байдаг Ачит нуур-Дэвэлийн арлын тусгай хамгаалалттай газрын захиргааг Баян-Өлгий аймаг дээр байгуулъя.

Захиргааны барилга, байгууламжийн асуудлыг улсын төсвөөр шийдчихэж болох юм гээд сайдтай би санал солилцож байсан. Манай аудитынхан ч ойлгох байх. Аливаа төрийн байгууллага хяналт тавихад хугацаа болон зардал хэмнэсэн оновчтой зохион байгуулалттай байх ёстой.

Тийм учраас 20 хувь эзэлж байгаа өөр аймаг дээр захиргаа байх, тухайн тусгай хамгаалалттай газрын 80 хувийнх нь хил хязгаар байрлаж байгаа аймаг дээр захиргааг нь байгуулах хоёр өөр ойлголт л доо.

Тийм учраас Б.Бат-Эрдэнэ сайд аа, яг Ногооннуур дээр байж байгаа Ачит нуур-Дэвэлийн арлын захиргааг манай аймаг дээр байгуулах хэвээрээ байгаа юу гэж. Товчхон асуулт.

Нэгдүгээрт, оновчтой, зардал хэмнэсэн, хугацаа хэмнэсэн, зохион байгуулалттай байгуулагдах ёстой шүү дээ. Тэгэхгүй 20-хон хувьтай аймаг дээр нь аваачаад байгуулчихдаг. Нөгөө байгаль хамгаалагчид маань газартаа хяналт тавих гээд хэчнээн зуун километр

бензин тос, цаг хугацаа үрээд. Нөгөө хяналт маань оновчтой болохгүй тохиолдлууд бас байгаад байгаа юм. Төрийн байгууллагыг оновчтой, хугацаа, зардал хэмнэсэн байдалтай байгуулах тал дээр. Тэр асуудал юу болж байгаа вэ гэж. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Б.Бат-Эрдэнэ сайд манай аймаг дээр удаа дараа очиж ажилласан. Сая мөн энэ 3 сарын дундуур биечлэн очоод ажиллаад ирээд явж байгаа. Бас аялал жуулчлал тал дээр, тусгай хамгаалалтынхаа тал дээр анхаарал тавиад явж байгаа.

Энэ аялал жуулчлалыг дэмжих хүрээнд тусгай хамгаалалттай газар болон байгалийн цогцолборт газрууд дээр “tour camp” байгуулах. Энэ аялал жуулчлалыг дэмжих хүрээнд. Энэ газар олголтын асуудал, тусгай хамгаалалттай газар, байгалийн цогцолборт газрууд дээр аялал жуулчлалыг дэмжих хүрээнд яг яаж зохион байгуулагдаж байгаа вэ? Үүнийг яг иргэд болон одоо энэ аялал жуулчлалын бизнес эрхлэгчид аягүй ойлгомжтой хариултыг нь хэлчихмээр байна.

Одоо жишээлбэл, Алтай Таванбогд дээр “tour camp” байгуулах, хоолны газар, дэн буудлууд байрлуулах. Энэ дээр газар олголтынх нь асуудал яаж хийгдэж байгаа вэ? Жишээлбэл, манай аймаг дээр маш олон тусгай хамгаалалттай газрууд, байгалийн үзэсгэлэнт газрууд байдаг. Тийшээ ороод “tour camp” хийгээд буцаад хуулийн хүрээнд цэвэрлэгээ, янз бүрийн юмнуудаа хийгээд явчихдаг. Одоо бие засах газруудаа бас нэг соёлтой хийгээд явчих.

Хэрвээ тэгье гэх юм бол газар олголтыг нь яаж явуулж байгаа вэ? Энэ

аялал жуулчлалын бизнес, хувиараа эрхлэгчдэд аягүй товчхон ойлголт өгөөч гэсэн ийм хоёр асуулт байна. Б.Бат-Эрдэнэ сайдаас л байх шиг байна даа.

Б.Саранчимэг: 2 номерын микрофоныг өгье. Б.Бат-Эрдэнэ сайд хариулъя. 3 номерын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ. Т.Аубакир гишүүний асуултад хариулъя.

2022 онд Ачит нуур-Дэвэлийн арлын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Гутайн даваа-Хөмүүл голын эх байгалийн цогцолборт газрын захиргаа гэх мэтчилнээр ингээд 4 захиргааг байгуулсан.

Төсөв байхгүйтэй холбоотой энэ захиргаадунд зөвхөн цаасан дээр байгуулагдчихсан байгаа.

Увс аймгийн Бөхмөрөн сумын Засаг даргатай холбогдсон. Увс аймгийн Бөхмөрөн сумын Засаг даргаас манай Байгаль орчин, аялал жуулчлалын яам руу холбогдоод Ачит нуурын Дэвэлийн арлын захиргааны байр манай суман дээр бол бүрэн баригдаад дуусчихсан. Хүлээгээд авчихсан. Төсвийг нь тавьж өгөөч ээ гэдэг ийм асуудлыг хөндөж ярьсан.

Төсөвтэй холбоо бүхий асуудал нэгэнт Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төсөв дээр, сайдын багц дээр тавигдаагүй учраас энэ бол одоогоороо ямар ч боломж байхгүй гэдэг ийм хариултыг бид өгсөн. Албан ёсоор.

Тэгэхээр төсөвтэй холбоотой асуудлыг бид зайлшгүй хөндөх ёстой байгаа юм. Тэгж байж бүтэц,

бүрэлдэхүүн ажиллаж эхлэх боломж бүрдэнэ гэдэг хариултыг өгөх байна.

Хоёрдугаар асуулт, аялал жуулчлалыг дэмжих хүрээнд “tour camp” байгуулахтай холбоо бүхий асуудал. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулга Улсын Их Хуралд өргөн баригдсан. Дэд ажлын хэсэг ажиллаад явж байгаа. Ажлын хэсэг хуралдаад Улсын Их Хурлын Байнгын хороогоор хэлэлцэгдэж эхэлнэ гэдэг ийм хэлбэртэй байгаа.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр өргөн баригдсанаар улсын аялал жуулчлалын бүсийг байгуулах. Нөгөө талдаа өнөөдөр манай тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ нийт 21 хувь буюу 32.8 сая га газар байгаа. Үүнийг 2030 он хүртэл бид 30 хувьд хүргэх асуудал бий.

Өнөөдрийн байгаа үүссэн бэлчээрийн доройтол болон бусад нөхцөл байдлаас улбаатайгаар цаашдаа 30 хувийн хэмжээнд аваачихад бас тодорхой хэмжээний саад тотгорууд орон нутагт үүсэж байгаа.

Бид эдийн засгийн эргэлтийг сайжруулах, эдийн засгийг тэлэх хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгууд дээр “отоглох цэг” байгуулах. “отоглох цэг”-ийг хуулийн этгээд буюу хувийн хэвшлээр гүйцэтгүүлэхээр. Мөн нөгөө талдаа менежментийн хүрээнд хариуцан ажиллуулахаар ийм хуулийн өөрчлөлтийг бид өргөн барьсан байгаа.

Тэгэхээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны тухайн тусгай хамгаалалттай газар нутагт ажиллаж байгаа байгаль хамгаалагч болон тусгай хамгаалалтын захиргаадунд зөвхөн хамгаалалтын ажлаа хийх, хяналтын

ажлаа хийх чиг үүрэг хүлээнэ. Саяын таны хэлснээр “tour camp”, “отоглох цэг” байгуулах, тодорхой хэмжээний “отоглох цэг” дээр явуулах үйлчилгээг хувийн хэвшил явуулахаар ийм зохицуулалтыг бид Аялал жуулчлалын тухай хууль дээр оруулж өгсөн байгаа.

Төр менежментийг явуулна гэхээсээ илүүтэй хяналт, хамгаалалтыг хийх зарчим дээрээ Аялал жуулчлалын тухай хууль дээр тусгаж оруулсан байгаа. Баярлалаа.

Б.Саранчимэг: Т.Аубакир гишүүн тодруулья.

Т.Аубакир: Хоёр дахь асуудал ойлгомжтой л доо.

Эхний асуудал дээр энэ Ачит нуур-Дэвэлийн арал гэдэг бол үндсэндээ тусгай хамгаалалттай газрын 80 хувь нь Баян-Өлгий аймаг дээр байгаа. 80 гаруй хувь нь. Тийм ээ.

Тэгээд яг тэр Дэвэлийн арлын хажууд 500-хан метрт байж байгаа Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын Ховд баг гэж байгаа. Энэ дээр байр нь бэлэн байж байгаа.

Тэгээд ингээд төрийн байгууллага, хяналт тавьж байгаа байгууллага маань хугацаа, зардал хэмнэсэн зохион байгуулалттай байя. Төрийн өмч. Одоо тэр хяналт тавих боломж, зардал мөнгө, мотоциклоор тойрох хугацааг нь зардалтай нь хэмнэе гээд байхад л тээр тийшээ голын цаад талд Бөхмөрөн рүү л чирээд. Ямар ч учир байгаад байдаг юм. Б.Бейсен гишүүн бид хоёр үндсэндээ 2 жил гаруй энэ асуудлыг ярьж байгаа шүү дээ.

Зүгээр хар ухаанаар бодоод үзэхэд 500 метрийн цаанаас дурандаад харчих бололцоотой. 50 километрийн цаанаас мотоциклтой давхиад ирээд хяналт тавих хоёр бол шал өөр ойлголт л доо. Наад асуудлаа эргээд харсан нь дээр.

Б.Саранчимэг: Санал хэллээ. Ж.Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тусгай хамгаалалттай газар нутгийн хууль тогтоомжийн хэрэгжилт, бодит байдал ямархуу байна вэ гэдэг асуудал дээр Улсын Их Хурлын ажлын хэсэг гарч ажиллаад мэргэжлийн байгууллагууд, холбогдох байгууллагуудыг татаж оролцуулаад, тал бүрээс нь нэлээн нухацтай судлаад Байнгын хорооны тов тодорхой тогтоол гаргаж хүргүүлсэн.

Тэгээд тэр бол ер нь одоо байж байгаа хүндрэлтэй тулгамдсан асуудлуудаа олж харж шийдлийг нь тов тодорхой чиглэл болгосон ийм л тогтоол байсан.

Тэгээд Төсвийн байнгын хороон дээр аудитын хэлэлцэх асуудлын төлөвлөгөө орж ирэхэд зориуд бас үүнийг нийцлийн талаас нь асуудлуудыг харъя. Газар ашиглагч нарын эрх, үүргийн хангалт ер нь ямархуу байна вэ энэ тэр гэдэг талаас нь бас нэлээн анзааръя гээд аудитад тусгайлсан төлөвлөгөөнд нь тусгаж оруулж гүйцэтгэлийн аудит хийлгэсэн. Мэдээж мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдийг татаж оролцуулж, шинжээчдийн баг ажиллуулж их тодорхой хандсан байх гэж би ингэж ойлгож байгаа.

Аудитын байгууллагаас ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх ёстой бид.

Тийм учраас өнөөдрийн Байнгын хорооны хурлаас Засгийн газарт тов тодорхой чиглэл өгөх ёстой. Аудитын байгууллагын дүгнэлт, зөвлөмжид орсон асуудлуудыг хэрэгжүүлж ажиллалаа гэж. Бид юм үзээд тов тодорхой шийдэл гаргаад шийдлээ л хэрэгжүүлэхгүй юм бол ажил явахад үнэн мэдээж төвөгтэй. Бидний гаргасан шийдэл юмнууд багадаагүй гэдгийг зориуд хэлмээр байна.

Тийм учраас өмнөх аудитын дүгнэлтүүд хэрэгжүүлээгүйнх нь төлөө холбогдох улсуудад ямар хариуцлага тооцож байгаа юм. Аудитын байгууллага. Энэ талаараа тодорхой хэлмээр байна.

Хоёрдугаарт, тэр тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа нөхдүүд үүргээ хангахгүй, тэр битгий хэл төлбөрөө төлөхгүй байгаа дөчин хэдэн тэрбум төгрөгийн асуудал гарч ирээд байгаа энэ юман дээр ямар зохион байгуулалтын арга хэмжээ авхуулж хэрэгжүүлнэ гэж ойлгож байна вэ?

Энэ дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах талаар ер нь ямар ажил хийнэ гэж та бүгд төсөөлж байна вэ гэж нэг ийм зүйлийг тодруулмаар байна.

Сайдаас асуух ёстой болов уу гэж бодоод байна. Хуулийн шинэчилсэн найруулга орж ирэхгүй бол энэ хуулийн батлагдсан, өөрчлөлт орсон цаг хугацаа дэндүү алсарсан. Үүнээс болоод харилцаагаа зохицуулж чадахаа байчихсан юм билээ. Тэгээд энэ хуулийг маш яаралтай оруулж ирмээр байх юм. Засгийн газар Газрын багц хууль оруулж ирээд буцаагаад татаад аваад явчихсан.

Тэгэхээр зэрэг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль

нь ямархуу байдалтай яаж явах юм гэдэг асуудал бас их ойлгомжгүй ийм байгаад байгаа. Энэ талаар нэг тодорхой мэдээлэл өгөөч гэж.

Энэ хууль дотор хэд хэдэн зүйл байх юм байна л гэж хараад байгаа. Би бол.

Нэгдүгээрт, тусгай хамгаалалттай газар нутгуудын нэгж талбарын хилийн цэсийн эргэлтийн цэгүүдийг газарт бэхлэх тухай асуудал.

Хоёрдугаарт, тоон мэдээллийн системд бүрэн шилжүүлэх тухай асуудлыг бид хийхгүйгээр энэ маргаан цаашаа шийдэгдэхэд их төвөгтэй юм байна гэж ингэж харагдаад байгаа.

Хоёрдугаарт, тусгай хамгаалалттай газар нутаг бүр дээр ерөнхий төлөвлөгөө батлуулахгүйгээр болохгүй юм байна лээ. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлуулахгүйгээр болохгүй юм байна лээ. Хаанаа тэр хамгаалалтын бүс юмнууд нь байх юм, хаанаа тэр хязгаарлалтын бүс юм нь байх юм. Хязгаарлалтын бүс дотроо юу юу зөвшөөрч, аль байршил дээр байж болох юм гэдэг энэ бүх юмаа тэр газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөрөө нэгж талбар бүр дээрээ тодорхой урьдчилж харах ёстой юм байна гэж.

Хоёрдугаарт, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг заавал батлуулах ёстой. Тэгж байж тэр инженерийн дэд бүтэц, шугам сүлжээ, ашиглалтын чиглэл гээд энэ юмнууд бүгд голдиролдоо орох ёстой гэж ингэж ойлгож байгаа.

Гурав дахь зүйл. Энэ төрийн байгууллагуудын хоорондын мэдээллийн харилцааны асуудал байгаад байгаа юм.

Байгаль орчны яам мэдээж хуулиар олгогдсон эрх хэмжээнийх нь хүрээнд зориулалтаар нь газар олгож байгаа.../минут дуусав/

Б.Саранчимэг: Я.Сарансүх дарга. 4 номерын микрофоныг өгье. Нэр албан тушаалуудаа хэлээд хариулаад яваарай.

Д.Энхболд: Та бүхний өглөөний мэндийг хүргэе. Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл нийцлийн аудитын газрын захирал Д.Энхболд байна.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт, өмнөх аудитын зөвлөмжүүдийн хэрэгжилт хангалтгүй байгаа дээр ямар арга хэмжээ авч байгаа вэ гэдэг ийм асуудал тавьсан. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бид хувиар авч үзэхэд албан шаардлагын 60.7 хувь нь хэрэгжсэн байгаа. Зөвлөмжийн 67.5 хувь хэрэгжилттэй. 50-аас дээш хувийн хэрэгжилттэй байгаа учраас үүнийг эрчимжүүлэх зөвлөмжийг өгсөн. Хэрвээ энэ ажил хийгдэхгүй бол энэ дээр дараагийн шатын сахилгын арга хэмжээ авагдахаар манай Төрийн аудитын тухай хуульд заасан байгаа.

Мөн төлбөр мөнгөтэй холбоотой асуудал дээр бид 41.9 тэрбум төгрөгийн актыг тавьсан байгаа. Төлбөрийн актыг заавал хэрэгжүүлэх ийм хуулийн заалттай байдаг.

Мөн энэ дээр аудитын байгууллагын зүгээс ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байна вэ гэдэг дээр төрийн аудитын байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлэх тал дээр бусад улс орны туршлагын хувьд Байнгын

хороотойгоо хамтран ажиллаж аудитын зөвлөмж хэрэгжилтийг биелүүлэх шийдвэр, албан чиглэлийг Засгийн газарт өгдөг. Энэ маань бас тухайн салбарын үйл ажиллагааг эрчимжүүлэхэд онцгой ач холбогдолтой байдаг учраас энэ Байнгын хорооны хурлаас бид аудитын зөвлөмжийн дагуу тухайн салбар чиглэлд нь зөвлөмжийг хэрэгжүүлэх албан чиглэлийг өгөөсэй гэдэг ийм хүсэлттэй байгаа.

Үүргээ хангалттай биелүүлээгүй гэдэг асуудлууд дээр бид Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.8-д заасны дагуу суурин газрын ерөнхий төлөвлөгөө, шинээр байгуулах аялал жуулчлалын бааз, амралт, сувиллын байршил, төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран хянан баталж, зөвшөөрөлгүй буюу зориулалтын бус үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн газар ашиглах эрхийг нь дуусгавар болгох ийм зөвлөмжийг өгсөн байгаа.

Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд тийм мөрдөн шалгах, шууд шийдвэр гаргах эрх байхгүй учраас үүнийг холбогдох байгууллагуудад нь чиглэл, зөвлөмжийг өгч ажиллаж байгаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Саранчимэг: 3 номер нэмж хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Хуулийн шинэчилсэн найруулга бэлэн болсон байгаа. Газрын багц хуулийг дагалдуулж оруулахаар Монгол

Улсын Засгийн газар дээр ярьсан. Тусад нь оруулах боломжгүй. Газрын багц хууль буцаан татсан. Эргээд ахиж өргөн барихад нь цугт нь оруул гэдэг ийм шийдлийг ярьсан. Хаврын чуулганд багтааж оруулна.

Бид Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар яамдаас санал аваад дуусчихсан байгаа. Ер нь өргөн барихад бэлэн байгаа гэсэн үг.

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөөнөөс авхуулаад яах вэ, ер нь сая Зөвшөөрлийн тухай хуулийг дагалдаж Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн тодорхой өөрчлөлтүүдийг бид хийсэн. Тухайлбал, 6 дугаар зүйл дээр тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг бид оруулж өгсөн. Хуучин байснаас өөр нь юу вэ гэхээр тусгай хамгаалалттай газар нутагт ашиглаж болох газар нутгийн хэсгийг тодорхойлж төлөвлөсөн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны саналыг авсны үндсэн дээр батална гэдэг ийм заалтыг бид оруулж өгсөн.

Ингэснээрээ заавал төлөвлөгөөтэй байх. Төлөвлөгөөг нь үндэслэж байж батлах процессыг хуучин өнгөрсөн хугацаанд алдаа гарсан. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон дээр яригдаж байсан асуудлаас улбаатайгаар тодорхой хэмжээнд хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулсан.

Хоёрдугаарт, хамтын ажиллагааны асуудлууд бий. Жишээлбэл, сая нэмэлт, өөрчлөлт дээр бас дахиж нэмж хэлэх юм бол Аудитын газраас гарсан дүгнэлт дээр

улсын тэмдэгтийн хураамжийг төлөөгүй, гэрчилгээгээ аваагүй иргэдтэй холбоо бүхий асуудал мөн хөндөгдсөн.

Энэ дээр хуучин бид тухайн гэрчилгээгээ аваагүй иргэний гэрчилгээгээ аваагүй гэдэг үндэслэлээр ч юм уу шууд цуцлах эрх байдаггүй. Гэрчилгээгээ авахыг хүлээх, цуцлах үндэслэл нь өөрөө хуульд заасан үндэслэлээр л цуцалдаг учраас энэ боломжгүй нөхцөлтэй байсан дээр хуулийн нэмэлт тодорхой өөрчлөлтөөр бид гэрчилгээгээ аваагүй иргэдийн тухайн газрыг шууд цуцлах ийм бүрэн эрх үүссэн.

Бас нэг асуудал байгаа. Ямар асуудал байгаа вэ гэхээр саяын төлбөр хураамжтай холбоо бүхий асуудал дээр. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, тухайн газрын ашиглагчтай холбоо бүхий асуудал дээр тухайн компанийн дүрэмд өөрчлөлт оруулах хэлбэрээр гадаадын иргэд тухайн компанийн одоо дүрмийн хувьцаа эзэмшигчээр орж тухайн газрыг ашиглаж байгаа нөхцөл байдал илэрсэн. Үүнтэй холбогдуулж бид Улсын бүртгэлийн ерөнхий газартай ер нь энэ газрын байршилтай холбоотой, дээрээс нь тухайн газар дээр үл хөдлөх хөрөнгө эзэмшиж байгаа ашиглагч нартай холбоотой үл хөдлөх хөрөнгө эзэмшигч нартай холбоотой мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газартай шууд онлайн солилцох энэ систем рүү зайлшгүй нэвтрэх ёстой.

Тэр утгаараа таны хэлж байгаа төрийн төв байгууллагуудын хоорондын уялдаа холбоо харилцааг сайжруулах, мөн Байнгын хороон дээр хөндөгдсөн тухайн мэдээлэлтэй болох асуудлуудыг

нэг тийш нь шийдвэрлэх боломжтой гэж харж байгаа.

Нэг хүндрэлтэй асуудал бий. Үүнийг бид олон удаа ярьж байгаа. Нийслэлтэй холбоо бүхий асуудал. Дуудаад ирдэггүй. Очоод уулздаггүй. Ингээд Нисэх, Яармагийн бүстэй холбоотой 2015 оных нь төлөвлөлт нь байгаад байдаг. Яг тэр төлөвлөлтөөр энэ уулын ам болгонд чинь том том хорооллууд барьчихсан ийм төлөвлөлттэй. Тэгээд бид Байгаль орчин, аялал жуулчлалын яам ялангуяа миний хувьд сайдаар томилогдсоноос хойш 5594 га газрыг хамгаалалтын бүс рүү оруулж Горхи-Тэрэлж дээр 55 мянга 202-ыг мөн хамгаалалтын бүсэд авч аль болох л энэ газрыг олгохгүй байх тал дээр бид ажиллаж байгаа.

Энэ дээр гэтэл нөгөө хил заагийн давхцалтай хамаарал бүхий асуудлууд нөгөө талдаа үүсээд өнөөдөр Байгаль орчин, аялал жуулчлалын яам шүүх дээр яг энэ давхцалтай олгогдсон газартай холбоо бүхий асуудал болон газрын төлбөртэй холбоо бүхий асуудал дээр олон шүүх хуралдаантай явж байгаа. Баярлалаа.

Б.Саранчимэг: Ж.Батжаргал гишүүн тодруулъя гэж байна.

Ж.Батжаргал: Тийм. Ер нь одоо ингээд явж байгаа үйл явцыг хараад тэр алдаатай байж болохоор үйл явцыг харахаар зэрэг тусгай хамгаалалттай газар нутаг бүр дээр газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлагдаагүйтэй холбогдоод дур зоргоороо байршиж сонгодог ийм үйл явцууд үүсчхээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүнийг бид хуульчилж өгөх ёстой юм байна лээ. Нэг.

Хоёрдугаарт, танайх мэдээж хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн ажил, үйлчилгээнд зориулж газар олгож байгаа нь ойлгомжтой. Би тэгж ойлгож байгаа. Гэтэл цаана чинь зураг төсөв, төлөвлөгөөг нь баталдаг байгууллагууд нь шал өөр эскиз төлөвлөгөө батлаад өгчхөөд байгаа байхгүй юу. Үүнийгээ шалгаж буруутай улсдаа хариуцлага тооцооч ээ. Ингэхгүйгээр наад ажил чинь явахгүй. Хууль зүйн хувьдаа үүнийгээ тодорхой болгооч ээ.

Дараагийн нэг зүйл. Орон нутгийн уламжлалт аж ахуйгаа эрхэлж байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалж ээлтэй орчин бүрдүүлэхгүйгээр бид цаашид энэ урт болоод дунд хугацааны бодлогын зорилтод байгаа тусгай.../минут дуусав/

Б.Саранчимэг: Тэгэхээр Тусгай хамгаалалттай газар нутгийн хуулийн хэрэгжилтийн ажлын хэсгийг Ж.Батжаргал гишүүн ахлаад маш өргөн хүрээтэй газар дээр нь очиж ажилласан.

Тэгэхээр өнөөдөр Байнгын хорооноос протоколоор үүрэг өгнө. Тэгээд манай гишүүдийн саналуудыг маш сайн протоколд орж байгаа. Тэгээд энэ дээр санал хэллээ гэж ойлголоо.

Дараагийнх Г.Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

Г.Мөнхцэцэг: Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийг өнгөрсөн жил Ж.Батжаргал гишүүнээр ахлуулаад ингээд бид ажилласан. Бүсчлээд ажилласан байгаа. Тэгээд Байнгын хорооноос тогтоол гараад.

Энэ тогтоолын ер нь хэрэгжилт одоо бас л хангалтгүй байгааг Үндэсний аудитын энэ тайлантай уялдуулаад харахад харагдаж л байна л даа.

Тэгэхээр 29 жилийн өмнө батлагдаж байсан энэ хууль өнөөдөр үндсэндээ 15 удаа өөрчлөлт орсон гэж тайланд туссан. Тэгэхээр яалт ч үгүй энэ хууль өөрөө бас ингээд хуучраад. Одоо хэрэгжилт нь өөрөө хангалтгүй болоод ингээд явж байгаагийн бас нэг зөрчил үүсэж байгаагийн нэг жишээ бол энэ яалт ч үгүй мөн л дөө.

Тэгэхээр бид энэ Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг яаравчлан шинжилсэн байдлаар нь оруулж ирэх нь нэн шаардлагатай байгаа гээд ингээд хоёр, гурван жил бид бас яриад л байна л даа. Тийм. Тэгэхээр одоо саналуудаа аваад дууссан гэж сайд тайлбар хэлж байх шиг байна.

Тэгэхээр заавал ингэж Газрын тухай багц хуультай оруулж ирэх нь одоо тийм зүйтэй юм уу, үгүй юм уу. Сайн мэдэхгүй байна.

Ер нь нэн шаардлагатай хурдан оруулж ирэх нь цаг үеийн шаардлага байна гэж ингэж харагдаж байгаа юм.

Тэгэхээр Үндэсний Аудитын тайланд ер нь тусгай хамгаалалттай Богд уулын захиргаа, мөн дээрээс нь Туул гол тойрсон нийслэлтэй холбоотой газар нутгууд дээр нэлээн их тийм дүн шинжилгээ хийсэн юм шиг байна.

Тэгэхээр бид бас ажлын хэсэг гараад ажиллахдаа ер нь бүсчлээд хийсэн. Ялангуяа говь, хээрийн бүс дээр бид ажлын хэсгийг нь ахлаад, миний хувьд ажиллаад ингээд явсан.

Тэгэхээр энэ Чойрын Богд, Хамрын хийд, Дэмчигийн хийд, Дэл Хөнжлийн уул гээд ингээд бүсчилсэн говийн бүсүүдийн тусгай хамгаалалттай газар нутгуудын захиргааг нь бий болгох. Дээр нь зэрэглэлийг нь ахиулах гээд энэ олон ажлуудыг, судалгаануудыг аль хэдийн хийгээд ингээд өгчихсөн байж байдаг.

Тэгэхээр энэ дээр ямар дүгнэлтүүд хийв ээ? Та бүхэн бас танилцав уу? Энэ тайланд туссан юм бол харагдахгүй байна.

Тэгэхээр энэ “Алсын хараа-2050” гэдэг урт удаан хугацааны бодлогын бичигт тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 2025 он гэхэд 27 хувьд хүргэнэ гэж байгаа. Тийм ээ. 2030 он гэхэд 30 хувьд хүргэнэ гэж байгаа. Өнөөдөр ийм бололцоо нөхцөлүүд чинь яг бүрдсэн байна уу, үгүй юү? Өнөөдөр яг хэдэн хувьд хүрчихсэн байгаа вэ? Энэ дээр сайд бас нэг тайлбар хэлбэл ямар вэ гэж.

Сайдад өгсөн зөвлөмж дотор бас байна. Энэ үйлчилж байгаа үнэ тарифыг шинэчлэх хэрэгтэй байна гэж. Үнэхээр төлбөрийн хувьд хуучирсан. Одоо яг төлбөр нь ямар хэмжээтэй байж байгаа вэ?

Ер нь 41.9 тэрбум төгрөгийн акт тавьсан гэж байна. Байгалийн нөөц ашигласны төлбөрөөс орлогын хувьд заасан хэмжээгээр нь байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хуваарилуулах, зарцуулах зардлын талаар бүх шатны Засаг даргатай хамтран ажиллах ёстой гээд үндсэн зөвлөмжүүдэд тусчихсан байгаад байна.

Тэгэхээр одоо ямар хувьтай байгаа юм? Ямар төлбөртэй байгаа вэ? Энэ дээр

сайд нэг тайлбар хэлээд. Тийм. Хариулт өгөөч ээ гэж.

Б.Саранчимэг: Б.Бат-Эрдэнэ сайд хариулъя. 3 номерын микрофон.

Б.Бат-Эрдэнэ: Г.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Өнөөдрийн Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг заавал Газрын багц хуультай хамтатган өргөн барих тухай асуудлыг хөндөж байгаа үндсэн суурь шалтгаануудын нэг нь энэ газартай холбоотой асуудал нэг мөр цэгцтэйгээр шийдвэрлэгдэх ёстой. Өнгөрсөн хугацаанд хууль болгон тус тусдаа батлагдсанаас улбаатайгаар хоорондын хийдэл зөрчлүүд үүссэн.

Тийм учраас зайлшгүй Газрын багц хуультай өргөн барь гэдэг ийм чиглэлийг Засгийн газар дээр ярьсан. Бид тусад нь өргөн барь гэхэд бид нарын хувьд, манай яамны хувьд бэлэн байна.

Хамгийн их Газрын хууль дээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай тодорхой хэмжээнд зөрчилддөг гэдэг юм уу, тодорхой зайлшгүй зөвшилцөл хийх шаардлагатай газар бол Барилга, хот байгуулалтын яам байдаг.

Барилга, хот байгуулалтын яам болон Байгаль орчин, аялал жуулчлалын яам тодорхой хэмжээнд зарчмын зөрөөтэй саналуудаа нэгтгэх ажлуудыг зайлшгүй хийх шаардлагатай байгаа. Тэр утгаараа ч гэсэн Газрын багц хуультай холбоотой нэгтгэж өргөн барина гэдэг ийм зүйл яригдсан болов уу гэж бодож байгаа. Засгийн газар дээр.

Шинэ захиргаадудыг байгуулж болж байгаа. Төсөв байдаггүй. Төсөв нь байвал бид байгуулаад яваад байхад

бүрэн дүүрэн боломжтой байна. 2022 онд байгуулагдсан 4 захиргаа бэлэн байна. Төсөв байхгүйгээс улбаатай өнөөдөр үйл ажиллагаа нь хэрэгжиж чадахгүй хэлбэр дээр хүний нөөц, боловсон хүчнийг бид шийдвэрлэж чадаагүй байдалтай байгаа.

Тэгэхээр санхүүжилт буюу төсөв шийдэгдсэн тохиолдолд бид захиргаадудыг нэмээд яваад байх бүрэн дүүрэн боломжтой.

Тусгай хамгаалалттай газар нутагт өнөөдөр Монгол Улсын нийт газар нутгийн 21 хувь буюу 32.8 сая га газар яг тусгай хамгаалалтад байна. Манай тусгай хамгаалах газар нутгийн тухай хуулиараа. Хураамжтай холбоо бүхий асуудал дээр сая бид шинэчилсэн. Журам гарсан. 2023 оны 01 дүгээр сарын 06-ны батлагдсан нэмэлт, өөрчлөлтөөр бид хураамжийг сайдын журмаар шийдвэрлэхээр заалт оруулж батлагдсан байгаа. Үүний хүрээнд хуучин нэвтрэх хураамж монгол хүн 300 төгрөг, гадаад хүн 3000 төгрөг байсан. Үүнийг бид нэмж байгаа. Тэгэхдээ тухайн Аялал жуулчлалын тухай хуультайгаа нийцүүлж бид тодорхой хэмжээнд түрүүний хэлсэнчлэн тусгай хамгаалалттай газар нутгууд дээр тодорхой менежмент хэрэгжүүлж “отоглох цэг” байгуулах, эдийн засгийн эргэлтэд оруулахтай холбоо бүхий асуудал дээр дүйцүүлж бид энэ төлбөр, хураамжийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байгаа.

Нэгдүгээрт, орон нутгаас өөрсдөөс нь санал авч байгаа. Өнөөдөр хамгийн доод хэмжээ монгол, гадаад гэлгүйгээр 3000 төгрөгөөр очихоор ийм төлөвлөлттэй байгаа. Цаашдаа тодорхой газар нутгаас менежментээсээ шалтгаалаад өөр өөр байхаар ийм зохицуулалтуудыг бид хийж өгч байгаа.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуультай холбоо бүхий асуудал бид 2022 оноос хөндсөн. Бүр Авлигатай тэмцэх газар луу тодорхой албан тушаалтнуудын асуудлыг хөндөх хэмжээнд очсон.

2023 оны аймгийн Засаг дарга болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нартай байгуулсан гэрээнд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар заавал хэрэгжүүл гэдэг ийм гэрээг нэг талдаа байгуулсан. Уг нь энэ хуультай. Хуулиараа явах ёстой. Хуулийг хэрэгжүүлэхгүй байгаа аймгийн удирдлагуудтай холбоо бүхий сумын удирдлагуудтай холбоо бүхий асуудал. Энэ дээр тодорхой кэйсийг гаргаж тодорхой хэмжээнд үр дүнд хүрэх байдлаар бид цаашдаа ажиллаад явна гэдэг ийм байдалтай байгаа.

2022 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн нийт төвлөрсөн орлого болон хэрэгжилтийн бүх дүнгүүдийг бид цуглуулаад байж байна. Энэ дээр 50 хувиас доош гүйцэтгэлтэй байгаа тухайн албан тушаалтнуудыг бид өнгөрсөн 2022 онд хангалттай хэмжээнд сануулсан учраас тэр хууль хяналтын байгууллагад нь шилжүүлээд цагаан дээр хараар бичсэн энэ хуулийг хэрэгжүүлээд л явна. Өөр ямар ч арга байхгүй болсон.

Б.Саранчимэг: Баярлалаа. Г.Мөнхцэцэг гишүүн тодруулъя.

Г.Мөнхцэцэг: Б.Бат-Эрдэнэ сайд аа, сая өөрийн чинь хэлсэн хариултад ер нь ингээд төлбөрийг нэг жигдлээд 3000 болгочхож байгаа юм уу? Тийм ээ. Тэгж ойлгогдоод байна.

Тэгээд ер нь яаж нарийвчилж гаргасан төлбөр юм бэ? Энэ хэмжээ нийцэж байгаа эсэхийг нь нэг тодруулаад

хэлчихвэл ямар вэ гэж ингэж бодож байна.

Түрүүчийн миний асуусан асуулт нь бүсчилж бид явж ажилласан. Тэгэхээр зөвхөн дархан цаазтай Богд уул захиргааны асуудал биш. Туул гол тойрсон асуудал биш. Ер нь Монгол улс даяараа энэ олон газруудыг тусгай хамгаалалтад авах ёстой асуудлууд байгаа гэдгийг түрүүн би хэлээд байсан. Тэгэхээр энэ дээр тодруулаад хэлээд өгмөөр байгаа юм.

Тэгэхээр 2025 он гэдэг чинь бараг л маргааш болох гэж байгаа шүү дээ. 27 хувьд хүргэнэ гэж байна. Өнөөдөр 21 хувьтай байна гэж байна. Тийм ээ.

Тэгэхээр нэг жилийн хугацаанд 27 хувийн хэмжээндээ хүргэж чадах тийм боломж ер нь байгаа юм уу, үгүй юм уу? Энэ дээр тодруулаад нарийвчилсан нэг хариулт хэлээдэх үү.

Б.Саранчимэг: Тодруулгад хариулъя. 3 номер уу?

Б.Бат-Эрдэнэ: Г.Мөнхцэцэг гишүүний тодруулгад хариулъя.

Төлбөрийг бид ангиллаар нь оруулж байгаа. Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газар гэдгээр нэгдүгээрт.

Хоёрдугаарт, иргэн мотоцикл, суудлын автомашин, 12 хүний суудалтай автомашин 12-оос 24 хүний суудалтай, 24-өөс дээш. Мөн тодорхой хэмжээнд ачааны автомашин буюу 3.5 тонн хүртэл бодит жинтэй. 3.5 тонноос дээш бодит жинтэй. Мөн нисдэг тэрэг болон онгоцны асуудлыг бид оруулж ирж байгаа.

Сүүлийн үед ерөнхий зохицуулалтын агаарын тээвэртэй холбоо бүхий асуудлууд бас нэлээн хөгжих шатдаа ороод явж байгаа учраас. 5 хүртэл хүний суудалтай нисдэг тэрэг. 5-аас 12 хүний суудалтай нисдэг тэрэг. 12-оос дээш суудалтай гэж ингэж бид бас тодорхой ангиллуудыг бүр тус бүрчлэн гаргаж өгсөн байгаа. Тухайлах юм бол тусгай хамгаалалттай газар нутаг дээр дархан цаазат газар дээр иргэн 5000, байгалийн цогцолборт газар.../минут дуусав/

Б.Саранчимэг: Баярлалаа. Г.Дамдинням гишүүн асуултаа асууя.

Г.Дамдинням: Байгаль орчны сайдаас хоёр асуулт байна.

Нэгдүгээрт, энэ Дунд голын хязгаарлалтын бүсэд баригдаж байгаа усан парк гээд. Олон нийтээрээ л, нийгэм даяараа л асуугаад байдаг. Тэгээд таны эрх мэдэл хэмжээнд ер нь та ямар арга хэмжээ авсан юм? Үүнийг зогсоох талаар.

Саяхан төрийн хяналтын байгууллагууд, Мэргэжлийн ерөнхий газар гэсэн үг. Болиод таны харьяанд очсон. Өөрөөр хэлбэл мэргэжлийн хяналтын байцаагчдаа явуулаад зогсоох, хуулийн арга хэмжээ авах эрх нь танд бүрэн оччихсон байгаа. Ямар арга хэмжээ хийж байна?

Миний ойлгосноор Дунд голын хязгаарлалтын бүсэд хууль бусаар газар олгосон гээд Байгаль орчны яамнаас тэр газрын захиргаанаас нь бичиг гаргасан байна лээ. Та бас өмнө нь надад энэ Байнгын хорооны хуралдаан дээр энэ бол хууль зөрчсөн гэж манай яам үзэж байгаа гэж мэдэгдсэн. Олон нийтэд бас мэдэгдсэн.

Тэгэхээр үүнийг зогсоох талд ер нь ямар арга хэмжээ авч байгаа юм? Хэрвээ энэ дээр хуулийн ямар нэг үйлдэл хийж зогсоохгүй бол тэр дунд гол чинь өгсөөд тэр шинэ гүүр хүртэл. Тэгээд түүнээс дээшээ дахиад л барилга бариад л явлаа шүү дээ.

Олон улсын байгууллагууд, байгаль орчныг хамгаалах байгууллагуудаас өгч байгаа зөвлөгөөнүүдээр бол та нар, бид бүгдээрээ л мэдэж байгаа. Улаанбаатар хот цэвэр усны хомсдолд орж байгаа. Тийм биз. 2030 он гэхэд бид үндсэндээ тэгээд цэвэр усгүй болох юм байна лээ шүү дээ.

Тэгээд энэ дээр Байгаль орчны яам улсын чинь тал хүн амьдарч байгаа хотын цэвэр усны эх ундаргын энэ байгаа газар нь ингээд бүхэл бүтэн хороолол. Тэгээд л төр байхгүй юм шиг загнаад л, өдөр өдрөөр давхар нь нэмэгдээд л. Ингээд л би нэг хааяа дуугарах юм. Та нэг арга хэмжээ авч байгаа юм гэж дуугарах юм. Одоо ингээд энэ хотхон дууслаа шүү дээ. Энэ дээр ямар арга хэмжээ авч байгаа юм? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт, энэ Богд уулын дархан цаазат газар, тэгээд бас энэ дархан цаазат газруудад газар авсан компаниуд олон жилээр дарж газрын төлбөр нь хэдэн зуун сая болсны дараа компаниа дампууруулаад тэгээд өөр компанийн нэрээр дахиад л буцаагаад өөрсдөө аваад газрын төлбөр төлдөггүй гэсэн нэг ийм яриа яваад байх юм. Ийм юм байдаг юм уу? Байдаг бол та нар ямар арга хэмжээ авч байгаа юм бэ? Ийм хоёр асуултад тодорхой хариулт өгөөч.

Б.Саранчимэг: Б.Бат-Эрдэнэ сайд хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Г.Дамдинням гишүүний асуултад хариулья.

Өнгөрсөн жил Байнгын хороон дээр Г.Дамдинням гишүүн үүнийг асууж байсан. Би дахиад хэлье. Энэ хууль зөрчсөн үйлдэл. Нийслэлийн удирдах албан тушаалтнууд хууль ёсны дагуу гэж мэдэгдэж байгаа. Бид бол үүнийг хууль бус гэдгийг дахин дахин мэдэгдэж байгаа.

Улаанбаатар төмөр замын хэлэлцээрээр хүртэл энэ төмөр замын бүс орсон байдаг. Улаанбаатар төмөр зам яагаад энэ дээр өнөөдөр хүртэл чимээгүй байгаа гэдгийг ойлгохгүй байгаа юм. Улаанбаатар төмөр замын тодорхой удирдлагуудад бид 2022 онд бас энэ асуултыг тавьж байсан.

Яг ний нуугүй хэлэхэд өнөөдөр бид нийслэлийг жишээлбэл шүүхдэх боломж байхгүй. Захиргааны байгууллага захиргааны байгууллагаа шүүхдэх боломжгүй. Авлигатай тэмцэх газар дээр тодорхой эрх бүхий өмгөөлөгч нар Авлигатай тэмцэх газарт усан парктай холбоотой асуудлуудыг өгсөн. Энэ бол манай Туул голын сав газрын захиргаатай бас мэдээллүүдийг авч тухайн мэдээлэл дээр үндэслэж Авлигатай тэмцэх газарт өнгөрсөн жил өгч байсан. Үүний хариуг яг одоогийн байдлаар сонсоогүй байна.

Тэгэхээр Улаанбаатар төмөр зам энэ дээр тодорхой шийдвэрүүдийг гаргах ёстой. Энэ бол зөвхөн Байгаль орчин, аялал жуулчлалын яам гэхээсээ илүүтэй бүр ийм төмөр зам дагуух олон улсын хэлэлцээрээр орсон ийм асуудал байгаа юм.

Хоёрдугаарт, салбарын хяналт Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд

шилжиж ирсэн. Өнгөрсөн жил бид мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтраад хоёр ч удаагийн хяналт шалгалтын үйл ажиллагааг бид энд явуулсан. Усны сан бүхий газар. Дээрээс нь төмөр замын яг хажууд буюу энэ бол хүн амын амьдрах орчин биш.

Хоёрдугаарт, эрүүл мэнд, аюулгүй байдал, амь насны асуудал магадгүй ирээдүйд үүсэх маш хүнд нөхцөл бүхий барилга байгууламж. Үүнийг бид удаа дараа мэдэгдэж байгаа. Тэр утгаараа ч гэсэн зарим иргэд “Авлига хороолол” гэж энэ хорооллыг нэрлэсэн байдаг.

Тэгээд энэ дээр Засгийн газрын хурал дээр бас Монгол Улсын Ерөнхий сайдаас Барилга, хот байгуулалтын сайдад тодорхой чиглэлүүдийг өгсөн. Яагаад Дунд голын сав дагуу газруудаар барилга баригдаад байдаг юм бэ. Яагаад зөвшөөрлийг нь өгөөд байдаг юм бэ. Энэ өөрөө Монгол Улсын тодорхой хууль тогтоомжийг зөрчихсөн үйлдэл. Энэ газар олгосон этгээдээс авхуулаад тодорхой хэмжээнд мэдээллүүдийг олон нийтэд ил гаргаж тавь гэдэг энэ зүйлийг Засгийн газрын хурал дээр ярьж, хэвлэл мэдээллийн байгууллагаар, бас Засгийн газрын хэвлэл мэдээллийн цагаар мэдээлж байсныг хэлэх нь зүйтэй байх.

Цэвэр усны хомсдолтой холбоо бүхий асуудал үнэн. Цэвэр устай холбоо бүхий асуудал дээр өнөөдөр 1.6 сая. Ирж явж байгаагаа тооцвол 2 сая. Улаанбаатар хот, 5 аймаг, 37 сумын нутаг дэвсгэрээр урсаж байгаа энэ Туул голтой холбоотой асуудал Монгол Улсын хамгийн бохирдолтой гол. Хамгийн бохирдолтой гол.

Энэ дээр бид сая Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Цэнхэр алт” гээд үндэсний усны чуулган болсон.

Энэ чуулган дээр яг энэ Туул голтой хамаарал бүхий хайрга, дайргатай хамаарал бүхий, хогтой хамаарал бүхий, төв цэвэрлэх байгууламжтай хамаарал бүхий, мөн аялал жуулчлалын нэрээр Туул голын дагуу газар авч ашиглаж байгаа баар, ресторан, зочид буудлуудтай холбоо бүхий асуудлыг бид олон нийтэд ил тод гаргаж тавьсан ийм асуудал.

Одоо бид цаашдаа эндээс усны чуулганаас тодорхой ажлын хэсгүүдийг гаргаад Туул гол дээр дорвитой ахиц шинэчлэлийг гаргуулах замаар тусдаа ажлын хэсэг гаргаад байгуулаад явж байна.

Зөвхөн Туул голын дагуу тэр Шувуун фабрикийн тийшээ бид нарын тогтоосноор 32 тонн хог хаягдал байна. Яг Туул голын дагуу. 32 мянга байх аа. Тийм. Тэр тонн хог хаягдлыг бид тээж зөөж зайлуулах.../минут дуусав/

Б.Саранчимэг: Г.Дамдинням гишүүн тодруулъя.

Г.Дамдинням: Тэгээд энэ нэг ийм. Хүмүүс чинь бас шударга ёс хүсээд байна шүү дээ. Тэгээд нүдэн дээр нь ингээд доромжилж байгаа юм шиг болж байгаа үйлдэл дээрээ Байгаль орчны яам та мэргэжлийн хяналтын байцаагч нартаа өөр дээрээ авсан юм бол хүмүүсээ явуулаад арга хэмжээ аваад. Тэгээд одоо үүргээ биелүүлсэн нь дээрээ.

Монгол Улсын Засгийн газраас дээшээ гарсан эрх мэдэлтэй хүмүүс гэж юу байдаг юм бэ. Болиулах хэрэгтэй шүү дээ. Үүнийг. Тодорхой арга хэмжээ аваад Байгаль орчны байнгын хороогоор бид бас ярих ёстой байх аа. Б.Саранчимэг дарга аа. Тийм ээ. Хэдүүлээ. Өнөөдрийн арга хэмжээнээс бас үүрэг чиглэл өгөөд явчихсан нь дээр байх. Тийм.

Хоёрдугаарт, тэр Богд уулын газартай холбоотой, дархан цаазат газартай холбоотой асуултад хариулаач. Сайд аа.

Б.Саранчимэг: Протоколоор өнөөдрийн Байнгын хорооноос үүрэг даалгавар өгөгдөөд явчихна.

Б.Бат-Эрдэнэ сайд хариулъя. 3 номерын микрофон.

Б.Бат-Эрдэнэ: Г.Дамдинням гишүүний асуултад хариулъя.

Газрын төлбөртэй холбоо бүхий асуудал Газрын тухай хуулиар газрын төлбөр ноогдуулах буюу 9 дүгээр зүйлээр газрын асуудал эрхэлсэн байгууллагаас энэ асуудлыг хариуцдаг. Манай Байгаль орчин, аялал жуулчлалын яам руу аливаа төлбөрөөр төвлөрдөггүй. Газрын төлбөр төлөөгүй этгээдүүдтэй холбоотой дээр бол 2022 онд бид газрыг шууд цуцлах арга хэмжээнүүдийг авсан.

Хоёр жилийн хугацаанд ашиглаагүй, газар дээрээ ямарваа нэг зураг төсөл болон зориулалтын дагуу ашиглаагүй ийм газруудыг бид бас бүгдийг нь цуцалсан байгаа. Нийтдээ 259 орчим газрыг бид цуцалсан байдаг. Өнгөрсөн 04 сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний өдрүүдэд бид ийм газруудыг цуцалсан.

Газрын төлбөртэй холбоо бүхий асуудал энэ аудитын байгууллагаас дүгнэлт дээр орж ирж тодорхой хэмжээнд.../минут дуусав/

Б.Саранчимэг: Ойлгосон. Тийм ээ. Ш.Адъяаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьяа: Өнөөдөр тусгай хамгаалалттай газар нутгийн асуудлаар Улсын Их Хуралд аудитын дүгнэлт хийсэн тухай хэлэлцэж байна л даа.

Энд хоёр, гурван асуудлыг анхаарч үзэх ёстой гэж бодож байгаа. Энд шинэ хамгаалалтын захиргаа байгуулах тухай асуудлуудыг хөндөж ярьж байна. Энэ мухардалд орсон асуудал шүү. Хэмнэлтийн хууль гээд олон асуудал байгаа. Ноднин Ховд аймгийн Алтай суманд нэг хамгаалалтын захиргаа нэгтгэсэн чинь нэг Их Хурлын гишүүн ярьсаар байгаад авч цуцлаад үр дүнгүй олон байгууллага бий болгодог, нэгдсэн зохион байгуулалтгүй энэ асуудалдаа Засгийн газар бас анхаарч ажиллах ёстой байх. Түүнээс биш нэг газар нэг гэр бариад, дараагийн газар нэг гэр барьдаг энэ юм чинь улсын төсөв мөнгө, зардал гээд олон асуудал дээр анхаарах ёстой асуудал шүү гэдэг ийм байр суурьтай байна.

Дээр нь өнөөдөр Засгийн газраас шударга ёс, **“Таван Ш”** хөтөлбөр гээд л олон асуудлуудыг тавьж байгаа. Энэ 30 жилийн булхай луйврын чинь хамгийн бугшсан хэлбэр бол Богд уулыг тойрсон газар олголттой холбоотой асуудал байгаа гэдэг дээр бид санал нэг байгаа. Энд олон хүний эрх ашиг хөндөгдсөн, олон Их Хурлын гишүүд, олон эрх мэдэлтнүүдийн өмчилсөн газар байдаг. Энд хамгийн их буруутай асуудал байна. Улсын Их Хурал гэж үзэж байгаа юм. Би.

Хоёр жилийн өмнө Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо даргаар ахлуулсан Богд уулыг тойрсон нийслэлийн газрыг шалгана гэсэн Улсын Их Хурлын ажлын хэсэг байгуулагдсан. Өнөөдрийг хүртэл нэг ч юм шалгахгүй байгаа. Шалгая гэж. Би тэр

ажлын хэсэгт байдаг юм. Яагаад ч шалгахгүй байдаг юм.

Тэгээд л одоо нэг юм болохоор АТГ шалгаж байгаа, тэр шалгаж байгаа гэдэг. Тэгэхдээ өнөөдөр Б.Бат-Эрдэнэ сайд ирээд бас гайгүй ажиллаж байгаа гэж үзэж байгаа. Тэгээд нэг юм хийхээр нь дотор нь байсан хүмүүс халагдаад л сошиалаар олон асуудал ярьж байгаа. Тэгэхдээ энэ асуудал дээр Ардчилсан намын бүлэг бид тусгай ажлын хэсэг гаргаж шалгана. Энэ дээр.

Аудитын тухайд зөвлөмж гаргаад л байдаг, гаргаад байдаг. Зөвхөн Богд уул биш. Олон юман дээр зөвлөмж гаргадаг. Хариуцлага тооц гэдэг. Нэг ч хариуцлага тооцсон юм байхгүй байгаа шүү дээ. Үүнийгээ цаашдаа яах юм?

Дээр нь өнөөдөр Богд уулын захиргаа, Байгаль орчны яам, нийслэл хоёрын хооронд бөөн маргаан байна. Улсын Их Хурал үүнийг хагалах ёстой байхгүй юу. Нэгэнт төр буруу шийдвэр гаргаад олон аж ахуйн нэгжүүд, ард иргэдэд үл хөдлөх хөрөнгө бариулчхаад одоо хууль дүрэм ярьж болохгүй. Цаашдаа Улсын Их Хурал энэ хуулийг гаргаж батлаад тэр хүмүүст нь энэ хотын захиргаа, энэ яам хоёрын хоорондын зөрчлийг Улсын Их Хурал хагалж өгөх ёстой байхгүй юу.

Тэгээд л хот руу нэг юм яриад, Байгаль орчны яам руу нэг юм яриад дунд нь хаданд хавчуулагдсан халиуны зулзага хөөрхий гэдэг шиг яам нь муу нэртэй, бүүр болохоо байсан ийм юмыг одоо энэ Улсын Их Хурал шийдэх ёстой шүү. Үүнийг Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүд анхаарлаа хандуулах ёстой.

Тэнд өчнөөн хэдэн арван тэрбум төгрөг зарж үл хөдлөх яачаад өнөөдөр Богд уулын Дархан цаазын тухай юмыг яриад ниргэсэн хойно хашхирав гэдэг ийм юм байж болохгүй. Энэ дээр Улсын Их Хурал өөрсдөө энд буруутай байгаа шүү. Энд Б.Саранчимэг дарга анхаарах ёстой. Энд шийдвэр гаргах ёстой. Бид ийм л байр суурьтай.

Одоо өнөөдөр ингээд л нэг аудит хийж ирээд л нэг яам тамга шүүмжлээд л ингээд үр дүн гарахгүй ингээд л хурал, зөвлөгөөн, шалгалт гэдэг юмыг чинь бид хиймээргүй байна. Энд Улсын Их Хурал өөрсдөө энэ дээр зарчмын шийдэл, шийдвэр гаргаж, ард иргэдэд үүнийг ойлгуулж төр засгаа шийдвэрийг биелүүлэх нь.../минут дуусав/

Б.Саранчимэг: Манай Байнгын хороо хоёр ч одоо бүр яг энэ тусгай хамгаалалтаар илүү их анхаарч Ж.Батжаргал гишүүн, Т.Энхтүвшин гишүүнээр ахлуулсан хоёр ажлын хэсэг гараад Засгийн газарт чиглэл өгчихсөн байгаа.

Тэгэхээр өнөөдөр бид аудитын дүгнэлтийг сонсож байна гэдэг бол цаашдаа үр дүн гаргахын тулд явж байгаа. Тэгээд энэ дээр өнөөдрийн тэр санал, дүгнэлт гаргасны дагуу бас нэлээн ахиц гарсан гэж харж байгаа.

Ш.Адъяаа гишүүний асуултад Б.Бат-Эрдэнэ сайд хариулъя. Санал хэлсэн гэж байна. Санал хэлсэн. Н.Ганибал гишүүн асуултаа асууя.

Н.Ганибал: Өглөөний мэнд. Би хоёр асуудлыг ярья.

Богд уулын дархан цаазат энэ статус бол өнөөдрийн Монголын иргэдэд тэгш бус боломжийг олгоод байгаа юм.

Дарга нар, түүнтэй хамаарал бүхий бизнесменүүд болохоороо энэ боломжийг илүү эдэлж, тэгээд өөрийн гэсэн газартай. Мөн үл хөдлөх хөрөнгөтэй ийм болдог. Харамсалтай нь жирийн иргэд болохоор одоо хүртэл газраа авч чадаагүй Зайсангийн хэдэн хүмүүс байдаг. Тэр Туул голын хөвөөн дээр насаараа амьдарсан. Тэгээд тэрийг нь одоо хүртэл өгдөггүй. Ийм л байдлаар энэ дархан цаазтай Богд уулын асуудал өнөөдрийг хүртэл явж байгаа.

Би Б.Бат-Эрдэнэ сайдад итгэхгүй байна. Өмнөх хүмүүсийн гаргасан шийдвэр дээр гарын үсэг зурсан гээд Монголоор л нэг юм боллоо. Тэгээд дараа нь иргэд өөрөө гаргана л гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр энэ хууль тогтоомж энэ асуудлууд бүгдээрээ болохгүй байна. Өнөөдөр дархан цаазтай гэдэг энэ асуудал нь жирийн иргэдэд боломж олгохгүйгээр зөвхөн дарга нар, түүний хамаарал бүхий бизнесменүүд давуу эрх олгосоор өнөөдрийг хүрлээ.

Тэгэхээр бид энэ дээр бүр концепцоор нь өөрчлөх ёстой. Өөрчлөх ёстой. Яаж вэ гэж. Богд уулын дархан цаазыг болиулъя. Статусыг нь өөрчилъе л дөө. Яагаад заавал тэр дархан цааз гэдэг статусын ард эрх мэдэлтнүүд хожиж, тэнд авлигал бий болж, энэ явж байгаа асуудлууд чинь бүгдээрээ үүсээд байгаа байхгүй юу.

Тэгээд ойн зурвас руугаа оруулъя. Иргэн болгон тэнд эзэмших эрхийг нь өгүүлъя. Тэрийг нь харин зөв зохион байгуулж өгъе. Ингэж байж энэ асуудал үндсээрээ шийдэгдэнэ.

Түүнээс яг энэ байдлаараа явах юм бол энэ асуудал эргээд л яг дараа

дараагийн сайд нар, дараа нь Б.Бат-Эрдэнэ гэдэг хүн эргээд тэр авлигажсан тэр шийдвэрүүдийг гаргасан гээд цоллогдоод л явна.

Энэ ямар ч өөрчлөлт орохгүй. Энэ хувь хүнээс хамаарахгүй байхгүй юу. Энэ систем нь өөрөө буруу байна л гэсэн үг. Тэгээд иргэдийн энэ боломжийг олгох тал дээрээ “дархан цааз” гэдэг энэ нэр томъёолол. Тэгэхдээ түүний ард нуугдаж байгаа авлига, эрх мэдлийн шийдвэрүүдийг л үгүй хийх ёстой. Иргэдийн хяналтыг нь тавиулдаг байх ёстой. Иргэд тэндээ оролцоод эхлэх юм бол харин тэр зөв зохион байгуулалт, тэр харилцаанд ороод ирэх юм бол хяналтаа тавиад эхэлчихнэ. Ийм л асуудал байгаа.

Хоёр дахь асуудал нь, саяхан болоод өнгөрлөө. Энэ Дачин Тамсаг дээр болж байгаа процесс дээр Б.Бат-Эрдэнэ сайдаас асуумаар байна.

Та тэр ажлын хэсэгтээ тэр төрийн бус байгууллагын хүмүүсийг оруулсан юм уу? Үнэхээр та өөрийнхөө доор ажиллаж байгаа байгаль орчны байцаагч нарт итгэхгүй болчихсон юм уу? Тэр хүмүүс чинь олон жилийн туршид боловсорч мэдлэгтэй болж ингэж тэр ажлыг хийж байгаа байх. Тэгээд яагаад өнөөдөр тэр төрийн бус байгууллагын хүмүүсийг Засгийн газар ажлын хэсэгтээ албан ёсоор гарын үсэг зурж оруулаад тэгээд нийгэмд ийм будилааныг үүсгээд. Тэгээд араас нь та нар магадгүй тэр Дачин Тамсаг руу шалгалт оруулаад гэрээ цуцлуулах тийм ажлыг хийгээд эхэлчихсэн юм биш биз?

Үнэхээр гадаадын хөрөнгө оруулалтыг оруулж ирнэ, хамгаална, дараагийнхыг нь оруулж ирнэ гэж байгаа бол одоо байгаа сайн муу гэрээ хийгдсэн

тэр тухай тухайн Засгийн газар нь хариуцлагаа хүлээнэ биз.

Тэр гэрээнийх нь дагуу ажлуудыг нь хийлгээд бид бүхэн өөрсдийнхөө гадаадын хөрөнгө оруулагч нарт хэрхэн харьцаж байгаагаа илэрхийлэх ёстой. Түүнээс таны. Би тодруулж асууна.

Б.Саранчимэг: Б.Бат-Эрдэнэ сайд хариулъя. 3 номер.

Б.Бат-Эрдэнэ: Н.Ганибал гишүүний асуултад хариулъя.

Туул голын хөвөөн дээр амьдарч байгаа иргэд гэж ямар иргэдийг хэлээд байгааг ойлгохгүй байна. Тэрийг тодорхой өгөх нь зөв байх.

Горхи-Тэрэлж дээр бид 48 иргэнд газар олгосон асуудал бий. Тэр олон нийтийн хэвлэл мэдээлэл, сүлжээгээр явсан. Манайд ажиллаж байсан эрх бүхий албан тушаалтан мэдээллийг регистрийн дугаартай нь гаргаж тавьсан асуудал.

Энэ бол 2006-2011 онд аль хэзээний олголт хийгдээд гэрчилгээ нь хүчингүй болоод ахиад шинэ гэрчилгээ авсан хүмүүс.

Богд хан уулын дархан цаазат газар дээр бид 114 иргэнд газар олгосон. 114 иргэнд газар олгосон. Хамгийн сүүлд бид 12 сарын төгсгөлөөр 74 иргэнийг нийлүүлж 174 хүнээс шүүж байгаад 74 иргэнд хамгийн сүүлд бид газар олголт хийсэн. Үлдсэн 80 хүний асуудал байгаа. Магадгүй энэ 80 хүнтэй холбоотой асуудал хөндөж байгааг үгүйсгэхгүй байна. Тэр 80 хүнтэй холбоо бүхий асуудал бол нэг аж ахуйн нэгж тухайн газрыг нь худалдаж авахаар гэрээлээд байшин барихаар төлөвлөгдөж байгаа ийм газар юм билээ.

Тэгэхээр би яг тэр аль иргэнтэй холбоотой асуудлыг хөндөж байгааг мэдэхгүй байгаад байгаа учраас тэр дээр яг тодорхой хариулт бол би танд өгч чадахгүй байна.

Горхи-Тэрэлжийн холбоо бүхий асуудал дээр бол хэллээ.

Богд хан уулыг дархан цаазат газраас гаргаж болохгүй. 2012 оны Улсын Их Хурлын 2012 оны 38 дугаар тогтоолоор Богд хан уулын дархан цаазат газрын хязгаарлалтын бүс дэх Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны төмөр замын Туул зөрлөгийн 33.5 га газар нутгийг тусгай хамгаалалтаас чөлөөлсөн.

Өнөөдөр тэнд юу болж байна гэхээр хамгийн замбараагүй байдал тэнд үүсэж байгаа. Газрын маргаан, газрын наймаа. Хоорондоо газраас болж хүртэл асуудал үүсэж байгаа маш олон зүйл тэнд байгаа гэдгийг би танд хэлэхийг хүсэж байна.

Дачин Тамсагтай холбоотой асуудал дээр ажлын хэсэгт төрийн бус байгууллагын төлөөлөл ороогүй гэдгийг би танд албан ёсоор хэлье. Төрийн бус байгууллагын төлөөллийг бид тодорхой хэмжээнд ажлын хэсэгт оруулдаг. Гэхдээ Дачин Тамсаг дээр бид оруулаагүй. Цуг дагаад явж байгаа хүмүүсийг бид яаж ч чадахгүй. Яаж ч чадахгүй. Хөндлөнгийн хяналт хиймээр байна гэж бид нарт хүсэлт тавьсан. Хөндлөнгийн хяналтаа хийх нь өөрсдийнх нь бүрэн эрхийн асуудал.

Түүн дээр бид төрийн байгууллагаас албажуулж өгөх ямар ч боломж байхгүй учраас тухайн хүмүүс өөрсдөө явж байгаа гэж ойлгох хэрэгтэй.

Гэрээг цуцлуулахтай холбоо бүхий асуудал дээр бид оролцоод хөндөөд яваад байгаа зүйл байхгүй. Өнгөрсөн жил буюу 2022 онд Петровичтай холбоотой менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын яам баталж өгөөгүй гэдэгтэй холбоо бүхий асуудал Аюулгүй байдлын байнгын хороон дээр хөндөгдөж яригдаад тэндээс шийдвэр гарч бүр тэр төлөвлөгөөг нь баталж өг гэдэг шийдвэр гарсан шүү дээ. Тэгээд бид баталж өгсөн. Улсын Их Хурлаас ирсэн шийдвэр, энэ нэг талдаа.

Одоо бид тухайн аж ахуйн нэгж дээр хуулийн дагуу Монгол Улс тусгаар улс хуультай. Хуулийн дагуу ажиллах ёстой гэдэг үндсэн зарчмыг л барьж ажиллаж байгаа. Нөгөө талдаа бид тухайн зээрдтэй холбоотой асуудлуудыг хөндөөгүй. Тэр бол хоёр өөр газар. Сошиал орчинд тавигдсан дээр химийн бодист хордсон гэдэг асуудал байхгүй гэж ойлгож байгаа. Тэгэхдээ тэр мал эмнэлэг зоонозын төвийнх нь тэр судалгаа, шинжилгээ, сэг зэмээс авсан дээжээс хариу нь гарах байх гэж бодож байгаа.

Химийн бодисыг стандартын бус хэлбэрээр агуулж байсан нь 19 дүгээр талбай. Зээр их хэмжээгээр үхсэн нь 21 дүгээр талбай. Энэ хоёр талбайн хооронд 184 километр зайтай. Мэнэнгийн талд сая өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой тодорхой хэмжээнд үхсэн зээрийн сэг зэм байгаа гэдгийг мэдээлж байсан.

Монгол Улсад өнөөдөр 3 сая зээр байгаа. Тодорхой хэмжээнд зээр үхэж байгааг бид үгүйсгэхгүй.../минут дуусав/

Б.Саранчимэг: Н.Ганибал гишүүн тодруулъя.

Н.Ганибал: Яах вэ, иргэдийн хүсэлтийн дагуу газар олгож байгаа нь сайн байна. Тэгээд гол нь олон жил нутагшсан, тэр газар олголтын үед. Тэр нам, янз бүр хамаагүй. Би зүгээр энэ зарчмын асуудал яриад байгаа юм.

Засгийн газрын энэ яам хоорондын ажлын зохион байгуулалт муугаас болоод тэр чөлөөлөгдсөн газрын газар олголтын маргаан үүсэж байгаа нь бол асуудал мөн л дөө. Тэр бол зохион байгуулж байгаа Засгийн газрын л алдаа шүү дээ. Түүнээс ямар хувь хүмүүсийн тэр эдийн засгийн эргэлтэд оруулаад байшингаа бариад.

Ер нь яагаад жирийн иргэнд болохоороо уул усанд амьдраад, ой модны хажууд амьдраад цэвэр агаар амьсгалах яагаад боломж олдохгүй байгаа юм. Заавал тэр дарга нар, түүнийг дагасан тэр бизнесменүүд, мөнгөтэй хүмүүст тэр боломж нь олдоод байдаг нь л асуудал байхгүй юу. Тэрийг худалдаж авдаг тэрбум тэрбум төгрөгтэй тэр боломж хэсэг бүлэг хүмүүст л байгаа болохоос жирийн иргэнд олдохгүй байгаа шүү дээ. Үүнийг л яриад байгаа юм. Түүнээс зүгээр нэг удаагийн нэг үйл.../минут дуусав/

Б.Саранчимэг: Санал байна. Тийм ээ. Г.Ганболд гишүүн асуултаа асууя.

Г.Ганболд: Бид аудитын дүгнэлт сонсож байна.

Тэгээд ер нь аудитын байгууллагын орж ирж байгаа дүгнэлтүүдийг харахад их бөөрөнхий. Ерөөсөө л бүх бурууг хууль шинэчилж гарах руу чиглэсэн. Тэгээд болж өгвөл Улсын Их Хурал руу, дээш нь чиглүүлсэн л ийм шийдвэрүүд гаргадаг болжээ.

Ер нь хуулийн хэрэгжилт хуульдаа биш хэрэгжүүлж байгаа хүмүүстээ байгаа.

Тэгэхээр бид энэ дээр аудитын байгууллагын бүтцийг эргэж харах болсон юм байна. Ерөөсөө Их Хурал дээр бид энэ аудитынхантай хэзээ уулзаж байна гэхээр зэрэг нэг асуудлаар жилд юм уу, хоёр жилд нэг л уулздаг. Тэгээд нэг урт дүгнэлт гаргаж ирнэ. Тэгээд дүгнэлт гаргаж ирсний дараа хэрэгжилтийнх нь араас явж байгаа байгууллага ерөөсөө байхгүй.

Тэгэхээр аудитын байгууллага өөрөө акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтээ хангуулдаг тусдаа бүр бие даасан газартай болмоор байна. Бүр газартай. Тэр гаргасан зөвлөмж, шийдвэрүүдийнхээ араас хөөцөлддөг, түүнийхээ биелэлтийг улиралд, сар улирлаар нь гаргуулж байдаг. Ингэж явж байж энэ байгууллагууд чинь өмнө нь гаргасан шийдвэрүүд, зөрчлүүдээ дараа нь давтахгүй байхгүй бол тэгээд л араас нь яах ч үгүй ингээд яваад байхаар чинь ингээд урсгалаараа ингээд л яваад л. Тэгээд л байж байгаад нэг гүйцэтгэлийн аудит хийхээрээ нэг ийм юм байна. Энэ хуулиа жаахан өөрчлөхгүй бол болохгүй байна гээд л нэг мөлийсөн дүгнэлт. Бүх юман дээр ийм дүгнэлтүүд орж ирж байна.

Тэгэхээр бид Байгаль орчны сайдтай дараа нь харин аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаатай үүрэг өгч хангуулсных нь дараа Байгаль орчны сайдаас бид асуух юмнуудаа асуумаар байгаа юм.

Тэгэхээр энэ чиглэл рүү бид аудитын байгууллагын Их Хурлын харьяа байгууллагын хувьд бүтцийг нь

өөрчилдөг юм уу, бүтцэд нь нэмэлт оруулдаг юм уу. Ийм тусдаа газрууд оруулж явж байж л энэ асуудлыг шийдэхгүй бол одоо өнөөдөр оруулж ирж байгаа зүйлүүд дээр нь мэдээж бид урьдахыг нь нэг их уншаад байх боломж алга. Зүгээр дүгнэлтийг нь болон энэ илэрсэн зөрчлүүдийг нь л харж байна л даа.

Зөвхөн одоо ингээд 2020-2022 оны байдлаар 1317 иргэн, хуулийн этгээдийн 1445 нэгж талбарын газарт 41.9 тэрбум төгрөгийнх нь төлбөрийг төлөөгүй байгаа ийм л зөрчлүүд байна. Энэ мэтчилэнгээр ингээд ард нь гарсан 12 зөрчил дээр бид Байгаль орчны сайдад үүнийг арилгуулах чиглэлээр Байнгын хорооноос хугацаатай үүрэг өгөөд үүнийг яаж арилгуулсан гэдгээ бид харин сонсож байж Байгаль орчны сайдтай ярих ёстой.

Тэгэхээр энэ чиглэл рүү хэдүүлээ явахгүй бол тэгээд аудитын дүгнэлт орж ирэхээр нь нөгөө салбарынх нь хүмүүсээс юм асууж асууж байгаад л тэгээд л яваад өгдөг. Тэгээд үүнийг арилгуулах тал дээр бид анхаарах ёстой байна.

Тэгээд ер нь Байгаль орчны сайд цаашдаа тусгай хамгаалалтынхаа энэ олголтынхоо журмыг нэг эрс өөрчлөөд, дэглэм дэглэмээр ер нь хэсэгчилсэн төлөвлөгөө хийлгүүлээд, тэрийг нь төсөл, дуудлага худалдааг хослуулж хийдэг юм уу нэг ийм байдлаар жаахан нээлттэй хэлбэр лүү явахгүй бол. Нээлттэй байсныг хүмүүс мэдэхгүй байгаа учраас мэдээлэл давуу хүмүүс нь авч байна гэдэг ийм ойлголтууд яваад байна.

Тэгээд үүнийг өөрсдөө та нар санаачилж гаргаж ирэхгүй бол нийгмийн шахалтаар, ер нь нийгэм өөрөө шахаж байгаад л энэ болохгүй байгаа юмнуудыг гаргаж ирэхээр болчхоод байна шүү.

Тэгэхээр заавал нийгмийн шахалтад орж бөөн жагсаал тэмцэл болохоос өмнө өөрсдийнхөө санаачилгаар энэ гарсан зөрчлүүдийг арилгуулах тал дээр сайд ажлын хэсэг гаргаад энэ гаргасан 12 зөрчил тус бүрд нь.../минут дуусав/

Б.Саранчимэг: Аудитаас хариулт өгье. 4 номерын микрофоныг өгье.

Д.Энхболд: Г.Ганболд гишүүний асуултад хариулъя.

Аудитын байгууллагын бүтэц, зохион байгуулалттай холбоотой аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх тал дээр оновчтой хувилбарын асуудлаар ярьж байна.

Тэгэхээр аудитын байгууллагын хувьд дүгнэлт, зөвлөмжөө гаргаад энэ дээр Улсын Их Хурлын даргын энэ жил өгсөн үүрэг чиглэл байгаа. Аудитын байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлдэг, үр дүнтэй байлгахад хууль эрх зүйн ямар шинэчлэл байна вэ. Үүнийгээ намрын чуулганаас өмнө хуулийн төслөө оруулж ир гэдэг энэ тал дээр бид ажиллаж бусад улс орнуудын туршлагыг судалж байгаа.

Энэ дээр тухайлбал бусад улс орнуудын төрийн аудитын дээд байгууллага нь Байнгын хороод болон Улсын Их Хуралдаа дүгнэлт, зөвлөмжөө танилцуулдаг.

Энэ дээр нь Байнгын хороод хамтарч ажиллаж, тухайн байгууллагуудад үүрэг, чиглэл өгч шийдвэрийн хэрэгжилтийг нь хангуулах тал дээр хамтарч ажиллаж байгаа нь илүү их үр дүнтэй. Үүнийг манайх хууль, эрх зүйн шинэчлэл дээр оруулж ирье гэж бодож байна.

Тодорхой дүгнэлтүүдийн хувьд ерөнхий байна гэдэг шүүмжлэлийг хэлж байна. Тайлан дотроо бид нэлээд задгай зөрчлүүдийг нарийвчилсан байдлаар авч үздэг. Тухайлбал, энэ тайлан дээр түрүүний жишээлбэл шинээр захиргаанд баригдах хэрэгцээ шаардлага байгаад байхад төсөв хүрэлцэхгүй байна гэдэг дээр бид бас олон улсын байгаль хамгаалах холбооны сайн туршлагуудыг судалсан. Энэ дээр заавал төсвөөс зардал гаргаж шинэ захиргаадыг байгуулах биш, төр хувийн хэвшлийн түншлэлээр үүнийг байгуулах боломжууд байна гэдэг хувилбаруудыг тайлан дотроо нэлээн нарийвчилж бичиж өгдөг.

Тэгэхээр ерөнхий байдлаар зөвлөмж, дүгнэлт дээрээ оруулдаг учраас үүнийг нэлээд анхаарах шаардлагатай.

Хамгийн гол нь зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлт дээр Улсын Их Хурал дээр нэлээн шахалт, чиглэл, шийдвэр өгч ажиллавал аудитын дүгнэлт, зөвлөмж нэлээн хэрэгжих боломжтой байгааг Та бүхэн маань анхаарч үзээрэй гэж хэлэхээр байна. Баярлалаа.

Б.Саранчимэг: Г.Ганболд гишүүн. Б.Бат-Эрдэнэ сайд. 3 номер.

Б.Бат-Эрдэнэ: Г.Ганболд гишүүний асуултад хариулья.

2022 оны 06 сарын 17-ны өдөр батлагдсан 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж хэрэгжиж эхэлсэн Зөвшөөрлийн тухай хуулиар ялангуяа газартай холбоо бүхий асуудлыг дуудлага худалдаа болон сонгон шалгаруулалтаар зохион байгуулах хэлбэрийг шууд оруулж өгсөн.

Үүнийхээ хүрээнд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр яг саяын таны хэлдэг сонгон шалгаруулалтын хэлбэрийг оруулж өгсөн байгаа.

Сонгон шалгаруулалтыг оруулж өгөхдөө түрүүний Ж.Батжаргал гишүүний мөн хэлдэгчлэн нэг жилийн ерөнхий төлөвлөгөөнийх нь газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө дээр нь үндэслээд бид сонгон шалгаруулалтын журмаар олгохоор ийм зохицуулалтыг хийж өгсөн.

Тэгэхээр цаашдаа газар зохион байгуулалт болон газар олголт маш ойлгомжтой болох ёстой гэж харж байгаа.

2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш нэг ч газар олголт өнөөдрийг хүртэл хугацаанд хийгдээгүй байгаа. Яагаад гэхээр тухайлсан хуулиар нарийвчилсан харилцааг зохицуулж өгөхөөр Зөвшөөрлийн хуульд оруулсан. Түүний дагуу Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд 01 сарын 06-ны өдөр Улсын Их Хурлаас намрын чуулганд багтааж энэ өөрчлөлтийг оруулж өгсөн байгаа гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Дэглэмтэй холбоотой асуудлууд хөндөгдсөн. Дэглэм дээр яах вэ, одоо өргөн баригдаж байгаа Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль дээр дэглэмийн зохицуулалтуудыг бид “нийслэл, ногоон байгууламж” гэдэг утгаар суурин газрын дэглэмийн “хязгаарлалтын бүс доторх дэглэм” гэдгээр бид оруулж өгч байгаа.

Түрүүн Н.Ганибал гишүүн мөн хөндсөн. Нэгэнт үл хөдлөх хөрөнгө худалдаад авчихсан байгаа барилга, байшингуудыг бид цаашдаа яах вэ. Газар зохион байгуулалтын хувьд яах вэ. Татварын хувьд бид яах вэ гэдэг энэ гарц гаргалгааг Монгол Улсын Засгийн газар дээр яриад үүнийхээ дагуу Барилга, хот байгуулалтын яамтай зөвшилцөөд дэглэмийн асуудлуудыг бид оруулж ирж байгаа юм.

Тэгэхээр энэ дэглэмийн асуудал бол Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль батлагдаад явахад эцэслэгдэн шийдвэрлэгдье явна гэдэг ийм бодолтой байгаа. Баярлалаа.

Б.Саранчимэг: Г.Ганболд гишүүнд нэмж минут өгье.

Г.Ганболд: Тусгай хамгаалалттай газрын талаар яривал зөндөө л юм бий л дээ. Бид өнөөдөр яриад ч барахгүй байх.

Ер нь энэ тусгай хамгаалалттай газруудынхаа нэг онцлогийг нь харж байгаад энэ менежментийг нь эргэж нэг хараад. Одоо энэ Хустайн цогцолборт газрын нэг менежмент байна шүү дээ. Тийм ээ. Энэ Хустайн цогцолборт газрын менежментээр явчих юм бол бас аялал жуулчлалыг жаахан аваад, өөрөө өөрийгөө санхүүжүүлээд ингээд явах боломжууд бол байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр болохгүй бол зарим тусгай хамгаалалттай газар нутаг дээр менежментийн чиглэлийн үйл ажиллагааг нь өгөөд явчихвал бас аваад явчихаар Орхон, Орхоны хөндийн цогцолборт газар юм уу, аялал жуулчлалын гол том бүсүүд байна.

Ер нь тусгай хамгаалалттай газар бол дандаа л аялал жуулчлал хөгжих

боломжтой, байгалийн үзэсгэлэнтэй тийм л газрууд байгаа шүү дээ. Тэгээд энэ газруудаа ер нь менежментийг нь өөрчлөх чиглэлээр жаахан онцгой.../минут дуусав/

Б.Саранчимэг: 3 номерын микрофоныг өгье. Б.Бат-Эрдэнэ сайд.

Б.Бат-Эрдэнэ: Г.Ганболд гишүүний асуултад хариулья.

Аудитын газар дээр бас нэг дүгнэлт авчихсан. Энэ жоохон харамсалтай дүгнэлт. Хустай маань менежментээр явж байгаа. Маш их хэмжээний улсын төсвийг нөгөө талдаа хэмнэж байгаа. Бүр эсрэгээрээ улсын төсөвт маш их хэмжээний мөнгийг оруулж байгаа.

Тэгээд менежментийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Засгийн газар дэмжээд яваад байдаг. Гэтэл аудитын байгууллагын дүгнэлт бол Хустайд машин олгосон. Энэ бол хууль зөрчсөн үйлдэл гээд дүгнэлт гарчхаж байгаа юм.

Тэгээд Байгаль орчин, аялал жуулчлалын яам Хустай дээр хувийн менежмент, төрийн бус байгууллага ажиллуулж байгаа дээр машин техник, тоног төхөөрөмж, бусад юмаар дэмжинэ шүү дээ. Дэмжиж явах ёстой. Гэтэл энэ дээр жишээлбэл ингээд аудитын байгууллагаас дүгнэлт нь ороод ирж байх жишээтэй. Та нар хууль зөрчсөн байна гээд. Тэгээд үүнийг цаашдаа хууль эрх зүйн хүрээнд өөрчлөлтийг нь оруулж цэгцэлж явахгүй бол одоо бид Хомын талаас авхуулаад тодорхой хэмжээнд менежментээр хэрэгжүүлэх ажлуудыг үргэлжлүүлээд яв.../минут дуусав/

Б.Саранчимэг: Өнөөдөр бид аудитын дүгнэлтийг сонсоод гишүүд маань асуулт асууж дуусаж байна. Үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна.

Тэгэхээр энэ дээр би бас нэг товчхон үг хэлье гэж бодож байна. Тэгээд энэ аудитын асуулт асуугаад үг хэлье.

Тэгээд аудитын тайланг бид сонслоо. Тэгээд аудитын дүгнэлтээр тусгай хамгаалалттай газар нутгийн хууль, эрх зүй дутагдалтай байна, зөрчилтэй байна гээд энэ дээр хэлсэн байна л даа.

Тэгээд би Б.Бат-Эрдэнэ сайдыг ч гэсэн, Байгаль орчны яамыг яаралтай тэр Байгаль орчны багц хуулиа оруулж ирээч ээ гэж байгаа юм. Үүнийг хэзээ оруулж ирэхээр бэлтгэгдэж байгаа вэ? Өөрсдөө татчихсан. Байгаль орчны холбогдолтой 35 хууль үйлчилж байдаг ч гэсэн өөрөө 200-гаад хийдэл, зөрчилтэй гэсэн ийм дүгнэлт гарсан байсан.

Тэгэхээр үүнийгээ дахиж сайжруулаад оруулж ирье гэсэн байгаа. Үүнийг яаралтай оруулж ирэх шаардлагатай байна. Энэ дээр нэг асуулт асууя.

Нөгөө талаар энэ аудитын дүгнэлтэд өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй гэж байгаа юм.

Тэгэхээр энэ тохиолдолд ер нь Аудитын газраас хэрэгжүүлэх тал дээр ямар арга хэмжээ авсан бэ? Аудитын газрынхан нэг тодорхой хариулт өгөөч.

Дараагийн асуудал бол энэ аудитын зөвлөмж Улсын Их Хурал,

Байгаль орчны яаманд гэсэн хоёр субъектэд хандсан байгаа.

Тэгэхээр энэ хууль, эрх зүйн орчин үнэхээр зөрчилтэй байгаа энэ цаг үед Байгаль орчны яам бүх энэ 35 хуулийнхаа модификац хийгээд бүгдээрэнг нь одоо бас нэг хуулийг нь өөрөөр тайлбарладаг биш, яг ийм зөрчилгүй болгох тал дээр ажиллаач ээ. Манай Байнгын хорооныхон энэ дээр бас нэлээн санаачилж хэлэлцүүлэг зохион байгуулсан байгаа. Үүнийгээ нэг яаралтай оруулаач гэсэн нэг ийм санал байгаа юм.

Энэ тусгай хамгаалалттай газар нутгийн асуудлаарх бүх зөрчил, дутагдлыг арилгахад ганцхан Байгаль орчны сайдад зөвлөмж хүргүүлсэн нь шийдвэрлэгдэх үү? Засгийн газрын асуудал хариуцсан яам, нийслэл, орон нутгийн захиргаа гээд олон субъектын оролцоотой шийдвэрлэх асуудал. Энэ тал дээр нэг тодруулж өгөөч.

Нөгөө талаар Тусгай хамгаалалттай газар нутгийн хууль тогтоомж зөрчигдөж хэрэгжихгүй байгаа, байгаль, амьтан, газар нутгаа хамгаалах үндсэн зорилт хэрэгжээгүй, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглаагүй, газар олголт нь холбогдох хууль тогтоомжийг удаа дараа зөрчсөн, төрийн болон орон нутгийн байгууллагын үйл ажиллагаа уялдаа холбоогүй гээд дүгнэлтийг гаргасан байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурлаар баталсан тогтоолууд, манай нэгдэн орсон олон улсын конвенц, мөн олон улсын гэрээнүүдийг зөрчсөн гэсэн ийм дүгнэлт гарсан байгаа.

Тэгэхээр аудитын тайлан, гаргасан дүгнэлт тусгай хамгаалалттай газар

нутгийн байдал яаж ноцтой зөрчигдсөн нь энэ дүгнэлтээс харагдаж байгаа юм.

Тэгэхээр Байнгын хорооноос манай өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад тусгай хамгаалалтаар гурав дахь удаагаа хуралдаж байна. Дүгнэлтүүдээ гаргачихсан. Ажлын хэсгүүд гаргаад.

Тэгэхээр өнөөдрийн ажлын хэсгээс гаргаж байгаа саналууд болоод, мөн гишүүдээс гаргасан саналуудыг нэгдсэн дүгнэлтэд хүргээд хэрэгжилт дээр нь бид эргэж дахиж хэлэлцэнэ.

Өнөөдөр протоколоороо бид үүрэг, даалгавар өгөөд явчих юм. Түрүүн миний асуусан асуултуудад тодорхой хариулаад өгөөч.

Эхлээд Аудитын газраас асууя. Я.Сарансүх даргыг хариулахыг хүсэж байна.

Я.Сарансүх: Өмнө нь Үндэсний аудитын газраас 2019 онд иргэн, хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэх гэдэг сэдвээр нийцлийн аудит хийж 1 төлбөрийн акт, 8 албан шаардлага, 7 зөвлөмж өгсөн. Үүнээс төлбөрийн актын биелэлт нь 13.3 хувьтай, албан шаардлагын биелэлт нь 60.7 хувьтай, зөвлөмж нь 67.5 хувийн биелэлттэй байгаа.

Нийт өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 60-аас дээш хувьтай байгаа учраас бүрэн хэрэгжээгүй байна гэж үзэж дахин энэ зөвлөмжийг хэрэгжүүлэхийг саяын аудитаараа зөвлөмж олгосон байгаа.

Б.Саранчимэг: Түрүүн бас гишүүд ч хэлж байсан. Нэг нь асууж, нөгөөдөх нь хариулсан болох биш. Тийм ээ. Яг энэ дээрээ ингээд нэг тодорхой ажлууд. Нэг бичиг шидэлцсэн ажлууд бас биш ээ. Энэ дээрээ дахиад тодруулаад хариулаад өгөөч.

Д.Энхболд: Уг нь Төрийн аудитын тухай хуулиар өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тохиолдолд албан шаардлага, сахилгын арга хэмжээ авах ийм эрхтэй байдаг.

Гэтэл Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хувьд өмнө нь хоёр, гурван сайд солигдсон. Тухайн сайдад арга хэмжээ авах ийм нөхцөл бололцоо үүсээгүй.

Дээрээс нь хэрэгжилтийн хувьд 60-аас дээш хувьтай байгаа учраас үүнийг одоогийн сайд анхаарч ажиллаач ээ гэдэг ийм зөвлөмжийг өгсөн байгаа.

Түрүүний таны хоёр дахь асуултад дурдсан төрийн байгууллагуудын уялдаа холбоо хангагдаагүй гэдэг ийм дүгнэлт байна. Олон улсын конвенцод нэгдсэн гэрээнийхээ үүргийг биелүүлээгүй. Энэ дээр ямар асуудал байвал зүйтэй юм бэ гэдэг дээр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар болон Байгаль орчны яам, Татварын ерөнхий газрын мэдээллийн нэгдсэн сангийн уялдаа холбоо, бүртгэлжүүлэлтийг сайжруулах шаардлагатай байна.

Яагаад гэх юм бол гурван газрын мэдээлэл гурвуулаа хоорондоо зөрүүтэй. Одоо жишээлбэл төлбөрийн барагдуулалтын асуудлаар яахад өөр өөр мэдээллүүд, төлбөрийн үлдэгдэл өөр өөрөөр гарч ирэх. Тухайн газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгжийн хугацаа дууссан энэ тэр асуудлыг Газар зохион

байгуулалт, геодези, зураг зүйн газар дээр мэдээллийг Татварын Ерөнхий газарт өгдөггүй ийм уялдаагүй байгаа нь улсын хэмжээнд хуулийн хэрэгжилтийг хангахад бас учир дутагдалтай байна гэдэг үүднээс нэгдсэн байдлыг хангах тал дээр анхаарч ажиллаач ээ гэдэг ийм зөвлөмжийг өгсөн.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Саранчимэг: Б.Бат-Эрдэнэ сайд хариулъя. 3 номер.

Б.Бат-Эрдэнэ: Б.Саранчимэг даргын асуултад хариулъя.

Байгаль орчны багц хуультай холбоотой асуудал дээр хийдэл болон зөрчлүүд, давхцалуудыг арилгах ажлууд бүрэн хийгдэж дууссан. Хаврын чуулганд өргөн барихаар байгаа. Хүсэлт байна. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргаж байгаа албан тогтоол дээрээ бас энэ холбогдох байгууллагуудыг их сайн оруулж өгөөч ээ гэж хүсэх гэж байгаа юм. Ялангуяа газрын төлбөртэй холбоо бүхий асуудал дээр.

Яагаад гэхээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам 5 жилийн хугацаатай газар олгодог. 5 жилийн хугацаанд аливаа байдлаар солбилцол өөрчлөх ч юм уу, тухайн өөрчлөлт орохооргүй байвал 5 жил ирдэггүй.

Тэгээд 5 жилийн дараа ирээд газраа сунгуулах болохоор тэр үед төлбөр төлсөн төлөөгүй бусад нөхцөл байдалтай холбоо бүхий асуудлууд үүсдэг. Энэ дээр нэг газар хариуцсан, газрын асуудлаар эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага руу бас шийдвэр гаргаж өгөөч гэдэг хүсэлт байна.

Хоёр дахь нь, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар луу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хамтраад юмнуудаа хийгээд явъя гэдэг юм. Тэгээд одоо админ эрхээ хаахаас авхуулаад ингээд маш дураараа нэг хэсэг нөхдүүд байна. Ер нь бол.

Тэгээд энэ дээр ялангуяа нэгдсэн сан үүсгэхтэй холбоо бүхий энэ аудитын дүгнэлтийг үндэслээд нэг мэдээллийн сантай болох асуудлыг яг энэ Байнгын хорооны тогтоолд бас оруулж өгөөч ээ гэж хүсэх гэж байна.

Гуравдугаарт, Газрын багц хуультай холбоо бүхий асуудал дээр Барилга, хот байгуулалтын яамыг эргэж яаралтай өргөн барих асуудлыг оруулж өгөөч ээ. Тэгэхгүй бол Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль маань Газрын багц байдлыг дагалдаж орохоор, хамт өргөн баригдахаар явж байгаа учраас бас ингээд хүлээгдэх. Энэ нь өөрөө эргээд аудитын зөвлөмжийг бид дагаж мөрдөж хэрэгжүүлэхэд бас хүндрэл үүсэх нөхцөлүүд байна.

Тэгэхээр бид магадгүй одоо жишээлбэл 7 сард өргөн баригдаад хэлэлцэгдэж амжихгүй явсаар байгаад намар болчихдог. Намар эргээд бид асуудлууд үүсдэг. Энэ асуудал дээр яах вэ. Эргээд зөвлөмж маань яах вэ. Сая 67.3. Би андуураагүй бол дүнтэй байх шиг байна лээ. Тэгээд эргээд биелүүлээгүй гэдэг энэ асуудал руу бас Байгаль орчин, аялал жуулчлалын яам орчих вий дээ гэдэг ийм эмээлт байгаа учраас үүнийг бас тогтоолд оруулж өгөөч ээ гэж албан ёсоор хүсэж байна. Баярлалаа.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр ер нь би түрүүн ч гэсэн асуусан. Өнөөдрийн энэ аудитын дүгнэлтээр ганц

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад зөвлөмж хүргүүлээд байдаг нь шийдвэрлэгдэхэд чадахаар байгаа юу гэж асуугаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр ер нь энэ төрийн байгууллагуудын уялдаа холбоог бид илүү их холбоотойгоор ажиллуулахгүй бол нэг нь өөр юм ярьдаг, нөгөөдөх нь ингээд нөгөөдхийгөө үгүйсгэдэг ийм зүйлүүд гараад байгаа учраас одоо ялангуяа энэ хууль эрх зүйн орчин дээр бид хийдэл, зөрчлийг арилгах гээд Байгаль орчны яам бас энэ Байгаль орчны

багц хуулиа өргөн барих гэж байгаад баяртай байна. Үүнийг яаралтай оруулж ирээрэй.

Тэгэхээр өнөөдрийн аудитын дүгнэлт дээр бид яг энэ протоколоор үүрэг даалгавар өгнө. Тэгээд шийдэгдсэн эсэх тал дээр дахиж эргэж хуралдахаар байгаа.

Тэгээд өнөөдөр манай хуралд ирсэн эрхэм гишүүд болоод ажлын хэсэгхэндээ баярлалаа. Хурал өндөрлөлөө. /алх цохив/

Хуралдаан 01 цаг 35 минут үргэлжилж, 11 цаг 52 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД